



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-35

1. Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх	5-21
--	------

2. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Боловсролтой Монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх	21-35
---	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 26 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Б.Бейсен, Б.Найдалаа;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ш.Бямбасүрэн, А.Ганбаатар, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, М.Сарнай.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, мөн хүрээлэнгийн ахлах шинжээч Б.Бадамжав, Ж.Нарантуяа, У.Отгонмягмар, шинжээч Э.Чойсүрэн, Э.Батсэлэм, мэргэжилтэн Д.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо хариуцсан референт Б.Энхмаа нар байлцав.

Асуулгын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Асуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, мөн хүрээлэнгийн мэргэжилтэн Д.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан асуусан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Рэгдэлийг дэмжсэнээр тооцож, 42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Боловсролтой Монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, мөн хүрээлэнгийн ахлах шинжээч Б.Бадамжав, Ж.Нарантуяа, У.Отгонмягмар, шинжээч Э.Чойсүрэн, Э.Батсэлэм, мэргэжилтэн Д.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо хариуцсан референт Б.Энхмаа нар байлцав.

Асуулгын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Асуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Эрдэнэбат, Ц.Мөнхтуяа, Ж.Галбадрах, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн мэргэжилтэн Д.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан асуусан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Боловсролтой Монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 30 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 12 цаг 26 минут

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Эрхэм гишүүд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д зааснаар гишүүдийг сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулъя.

11 дүгээр тойрог Алтаншагай гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, 12 дугаар тойрог Тогтмолын Мөнхсайхан гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Дашмягмарын Сарнай гишүүн, 1 дүгээр тойрог Ганбатын Хосбаяр гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нар хүрэлцэн ирсэн байна аа.

Өвчтэй, чөлөөтэй Цэндийн Баатархүү гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нараа гишүүн.

Гадаадад томилолттой байгаа гишүүнийг танилцуулъя. Жадамбаагийн Баясгалан гишүүн, Буланы Бейсен гишүүн, Бадрахын Найдалаа гишүүн нар томилолттойгоо байгаа. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайд Наранбаяраас хандсан асуулгын хариултыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболдоос Боловсролтой Монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Эрдэнэбат гишүүн. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээнэ үү.

Өнөөдрийн 2 хэлэлцэх асуудал чухал 2 асуудал. Гэхдээ Өргөдлийн байнгын хороон дээр энэ төсөв хэлэлцэж байгаа ид үед цаг нь нэлээн тулчихсан 2 асуудал байгаад байгаа. Энэ ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудал нэлээн хоолой дээр ирчихсэн асуудал байгаа.

Өргөдлийн байнгын хорооноос үүнийг дэмжээд ер нь бол энэ цалин хөлсийг нэмэх эх үүсвэрийг бол нэмэх нь зүйтэй юм байна аа. Үүн дээр бол Төсвийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо мэргэжлийн байнгын хороод руу шилжүүлсэн дэмжиж.

Тэгэхээр энэ асуудлыг хэзээ хэлэлцэх вэ?

Хоёрдугаарт ахмадын асуудал гээд мөн ялгаа байхгүй нийтийн өргөдлийн дагуу ирсэн. 2 мэргэжлийн Байнгын хороод ингээд саналаа өгөх ёстой байгаа. Тэгэхээр ийм 3 нийгмийн хүлээлттэй байгаа 3 асуудлаар манай Байнгын хороо хэзээ хуралдаж тов дараалалд орох вэ? Би өнөөдөр уул нь орно гэж ойлгосон. Тэгээд өнөөдөр бол яг хэлэлцэх асуудлын дараалалт байсангүй.

Маргааш гэхэд яг энэ үндсэн дээр тэр хамтын маргаан үүсээд ажил хаялт орон даяар болохоор болчихсон байж байна. Тэгэхээр энэ цаг үеэ бид нар мэдрээд яг энэ асуудлыг яаралтай хэлэлцэх нь зүйтэй юм байна. Засгийн газар бол харж байхад цалин хөлс орлого тодорхой хэмжээгээр нэмье гэдэг дээрээ байх шиг байна. Салхи нь наашаа ирэх шиг боллоо. Нөгөө талд нь бол үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд нь ингээд тодорхой тоо тавьчихсан. Тэгэхээр энэ тал дээр Засгийн газар тодорхой чиглэл өгөх гэдэг ийм асуудлыг ер нь яривал яасан юм бэ?

Өөрөөр хэлбэл энэ цалин хөлс нэмэгдүүлэх асуудал дээр нь тодорхой эх үүсвэр тавьж орж ир. Их хурлын 40-өөд гишүүд гарын үсэг зурсан, зуруулсан. Ялангуяа энэ боловсролын ажилчдын цалин хөлсийг нэмэхгүй бол болохгүй юм байна. 2026 оны боловсролын жил болж байгаатай холбоотой гээд. Тийм учраас Их дийлэнх олонх нь ер нь цалин хөлс энэ ялангуяа энэ 2 суурь салбар дээрээ байгаа юм байна гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр цаг хугацааны хувьд бол манай Байнгын хороо маань бас энэ асуудлыг болж өгвөл өнөөдөр би энэ Нийгмийн бодлогын байнгын хорооноос Засгийн газарт тодорхой чиглэл болговол яасан юм бэ. Эх үүсвэр дээрээ хөрөнгө мөнгөө тавиад тэр төсөв батлахад нэлээн тулчихлаа. Тийм учраас энэ тал дээр ийм саналыг дамжуулж хэлмээр байна.

Л.Энхнасан: Эмч багш нарын цалинг нэмэх асуудлаар ажлын хэсэг байгуулах энэ тухай нийтийн өргөдлийг бол Өргөдлийн байнгын хороо хэлэлцсэн. Тэгээд төсөв чуулганаар орсны дараа Төсвийн байнгын хороо болон манай Байнгын хороо хамтарсан хурал хийхээр яригдсан.

Тэгэхээр ирэх 7 хоногт хурлын товд орох байх аа. Тодруулга Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Ойлголоо яах вэ тэр нь ч зөв байх. Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо 2 яаралтай тэгэхдээ шийдэх хэрэгтэй байна. Ирэх 7 хоногийн товд дарааллын хувьд орно.

Дээрээс нь ахмадын асуудал л байж байгаа. Хамтатгаад оруулах ийм цаг үетэй холбоотой төсөвтэй холбоотой энэ чухал асуудлууд дээр эхлээд өргөдлийнх нь асуудлыг хэлэлцэх нэг асуудал байгаа.

Дараа нь өргөдлийнх нь дагуу дэмжиж байгаад Байнгын хороод маань төсөвтэй холбогдуулан дахиад нэг хэлэлцэх асуудал байгаа. Тэгэхээр эхний ээлжид тэр тавьсан өргөдөл, саналуудын үндэслэл, санал шаардлагыг нь сонсмоор байна. Өнөөдөр яах вэ Наранбаяр сайд байх шиг байна. Би яг энэ болоод байгаа асуудалтай холбоотой тодруулж асуулт асууна аа. Энэ өнөөдөр хэлэлцэх асуудал ч их холбоотой юм байна.

Тийм учраас энэ тал дээр ирэх 7 хоногт ахмадын асуудлыг нэмээд нэг оруулаад ирвэл сайн байна. Өргөдлийн байнгын хороо өнөөдөр шилжүүлсэн. Санал дүгнэлтээ манай Байнгын хорооноос санал авах ёстой юм байна лээ. Энэ ахмадын тэтгэвэртэй холбоотой асуудлаар.

Л.Энхнасан: За ойлголоо. Ингээд өөр саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа орёе.

Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцье ээ.

Ажлын хэсэг. Ажлын хэсгийг оруулна уу? Наранбаяр Боловсролын сайд, Нарангэрэл Мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Цогзолмаа Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Должинсүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бат-Эрдэнэ Цахим боловсрол статистик мэдээллийн хэлтсийн дарга, Бадамжав ахлах шинжээч, Нарантуяа ахлах шинжээч, Чойсүрэн шинжээч, Батсэлэм шинжээч, Ганцэцэг мэргэжилтэн.

Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх журамтай. Энэний дагуу өнөөдөр хэлэлцүүлж байна. Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна.

Наранбаяр сайд асуулгын хариуг танилцуулна уу? Наранбаяр сайдын микрофоныг нээнэ үү?

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагийн 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 20 тоот бичгээр ирүүлсэн Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаарх асуултын хариуг хүргэж байна.

Нэгдүгээрт Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно. Мөн хуулийн 38.5.8-д өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан нөхцөлөөр төрөөс олгох тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт зээлийг санхүүжүүлнэ гэж тус тус заасан. Мөн түүнчлэн Дээд боловсролын тухай хуулийн 4.1.7-д сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт болон төлбөрийн чадамжийг харгалзан төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг тодорхойлсон байдаг. Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт нийт суралцагчдын сургалтын төлбөрийн 50 хувийн

хөнгөлөлтийг олгож байсан нь мөн хувийн сургуульд суралцагчдад ялгавартай тэгш бус хандаж байгаа талаар гомдол санал ирсээр байсан.

Мөн Улсын Их Хурлын Байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1.3-д тогтоосон шалгуур шаардлагыг хангасан, суралцагчдад тэтгэлэг, зээлд буцалтгүй тусламж олгохдоо Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэлд эрэлттэй мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээгээр эрэмбэлсэн зохицуулалтыг тусгах. Мөн 1.4-д зорилтот бүлэгт чиглэсэн буцалтгүй тусламжийг оновчтой бөгөөд тэгш, хүртээмжтэй хуваарилах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх гэсэн чиглэлүүдийг тус тус заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт нийт суралцагчдад олгож байсан санхүүгийн дэмжлэгийн зохицуулалтыг өөрчлөх шаардлага үүссэн юм аа.

Иймд Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх зээлийг эргэн төлүүлэх журамд орон нутгийн төрийн өмчит их дээд сургуулийн суралцагчдад төлбөрийн чадамжийг харгалзан сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгохоор туссан.

Мөн Засгийн газрын 2021 оны их, дээд сургуулийг сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрийн цогцолбор болгон Орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 321 дүгээр тогтоолын 2 дугаар заалт нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцогдсон. Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөр суралцагчдын сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг олгож эхэлсэн. Уг тогтоолоор 2022 онд 2617 суралцагчдад 3 тэрбум 360 сая төгрөг, 2023 онд.

Л.Энхнасан: Нэмж хариулъя.

П.Наранбаяр: 2023 онд 2876 суралцагчдад 4 тэрбум 509 сая төгрөг, Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын дагуу 2024 онд 1853 суралцагчдад 3 тэрбум 202 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Нийтдээ тус хөнгөлөлтөд 7346 суралцагчдад 11 тэрбум 72 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна аа. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчид нь 2022, 2023 онд гэрээ байгуулсан тохиолдолд тухайн жилд үйлчилж байсан нөхцөлийн дагуу 2024-өөс 2025 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтөд үргэлжлүүлэн хамрагдаж суралцсан байна.

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх.

Л.Энхнасан: Нэмж нэг минут өгье.

П.Наранбаяр: Журмын 9.2.5 дахь заалтад суралцагч нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн байх шаардлагыг тусгасан болно оо. Уг заалт нь 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс элсэн суралцагчид хамаарч

үйлчилж эхэлсэн. Түүнчлэн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит их, их, дээд сургуулиуд журмын агуулга шаардлагыг бүрэн дүүрэн ойлгоогүйн улмаас бүх суралцагчдад сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт олгоно гэсэн мэдээллийг олон нийтэд түгээж улмаар суралцагчдаас буруу ойлголттой хүсэлтүүдийг хүлээн авсан байна аа.

Сургалтын төлбөрийн хөнгөлөлт хүссэн оюутнуудын өргөдлийг сургалтын байгууллага хүлээн авч шалгуур шаардлагад нийцсэн суралцагчдын мэдээллийг Боловсролын зээлийн санд хүргүүлдэг. Сан нь уг мэдээлэлд үндэслэн санхүүжилтийг баталгаажуулж олголтыг зохион байгуулдаг. 2024 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 14 их дээд сургуулийн нийт 1853 суралцагч сургалтын төлбөрийн хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлтөд хамрагдаж нийт.

Л.Энхнасан: Баярлалаа. Асуултдаа хариулахдаа дараа нь нэмээд ярьж болох байх аа.

Ингээд асуулгын хариутай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. ингээд Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Галбадрах гишүүнийг нэмж оруулна. Үүрийнтуяа гишүүнийг нэмж оруулна уу? Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа.

Саранчулуун гишүүн асуултаа асууна уу?

О.Саранчулуун: Өглөөний мэнд бид нар өнгөрсөн жил Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдаад тэгээд энэ журам дээр шинэчлэлт өөрчлөлтийг оруулсан. Тэгээд тэрэн дээр нэг асуудал одоо болтол яваад байгаа нь энэ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын асуудлууд байгаа. Тэгээд би энэн дээр ер нь ямар өөрчлөлт яг энэ журамтай холбоотой ямар ахицыг оруулж ирсэн бэ гэдгийг асуумаар байгаа юм. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дээд боловсролд суралцах журмыг засаад оруулаад ирсэн чинь материал өгсөн хүүхдүүдийн тоо нэмэгдээд ирсэн. Материал өгсөн хүүхдүүдийн тоо нэмэгдээд ирэхээр бид нарт ингээд энэ дээр чинь мөнгө байхгүй шүү дээ гэдэг асуудлыг Боловсролын яамнаас хариу өгсөн байгаа. Одоо болтол над дээр шүүх дээр яваад байгаа ээж, аав нар байгаа. 16, 17 ээж, аав байгаа бид нар хамтдаа тэр нөгөө юуны хурлын дундуур уулзсан шүү дээ. Тэгэхээр тэр хүүхдүүдийн асуудлуудыг ер нь яахаар болсон бэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт ер нь цаашдаа яах юм? Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дээд боловсрол эзэмшихтэй холбоотой зардлыг нь яг энэ тодорхой 2 хүн байхад л болно шүү дээ, 10 хүн байхад л болно шүү дээ. Яасан их хүн сурдаг юм гэж ингэж ярьсан хандлагатай байх юм уу. Ингээд нөгөө өнөөдрийн байдал чинь яг тийм болчихоод байгаа байхгүй юу. Журмыг нь шинэчлээд доторх агуулгыг нь жоохон сайжруулаад хүүхдүүдийг сураад ороод ир гээд хэлтэл энэ ч болохгүй, тэр ч олдохгүй гээд ингээд тэнцсэн тэнцээгүй гэдэг асуудлаар ингээд юу яагаад эхэлсэн гэсэн үг.

Тэгэхээр одоо энэ жил 16 хүүхэд байна, дараа жил 30, 40 хүүхэд орж ирвэл яах юм цаашдаа. Энэ дээр та нар ямар бодлогын төлөвлөгөө эсвэл шинэ зүйлүүд оруулж ирсэн бэ? Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч? Яагаад гэвэл жил болгон 10, 12 дугаар ангийн хүүхдүүд сурч байгаа, төгсөж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд нэмэгдэж сурна. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юу ч хийж чаддаггүй, мэргэжилгүй, боловсролгүй гэж ад үзсэн хүмүүсийнх нь тоог

байлгаад баймааргүй л байгаа бол тэд нарыг сургуульд сургуульд сурахад нь их дээд сургуульд сурахад нь боловсрол эзэмшихэд нь төрөөс дэмжих ёстой шүү дээ.

Тэгээд материалаа өгөхөөр дундуур нь ингээд алагчлаад ингээд хасаад байдаг энэ асуудал дээр яг тодорхой ойлгомжтой мэдээлэл авъя.

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна уу? Баярлалаа.

П.Наранбаяр: Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суралцах эрхийг бүрэн дүүрэн хангах ёстой энэ зарчимтай Саранчулуун гишүүнтэй яг ижил байр суурьтай байна. 16, 17 хүн өгөөд энэ жил 4 тэнцлээ. 4 тэнцээд ингээд тэтгэлгээ аваад явж байгаа. Үнэхээрийн журам нь өөрөө жишээлбэл дээд боловсрол эзэмшихэд зориулсан дэмжлэг байхад зарим нэгэн тохиолдолд жишээлбэл тогоочийн мэргэжил эзэмшихээр Австралид сурна ч гэдэг юм уу тэгээд тэр нь дээд боловсрол биш энэ журам нь өөрөө дээд боловсрол эзэмшихэд зориулсан ийм журам байхад тэрүүгээр их шат, шатын байгууллагад эрхээ хангуулахаар хандсан эцэг эх бол бий. Гэхдээ журам өөрөө дээд боловсрол учраас бидний хувьд энийг хангахад хэцүү бэрх учраас Австралийн ЭСЯ-нд хандаж дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Ийм зүйлүүд байгаа.

Цаашдаа бас энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бид энэ журамдаа хөнгөлөлттэй заалтууд нэлээн оруулсан. Ийм байгаа. Гэхдээ зарим нэгэн шаардлага дүнгийн голч эд нар гэсэн ийм шаардлагаас болж хасагдсан ийм харамсалтай тохиолдол гарсан. Энэ зүйлүүд дээр нарийн нарийн ийм мэдээллүүд байгаа учраас энэ тал дээр танд тусгайлан бид хариугаа өгөхөд бэлэн байна. Яагаад гэвэл энэ дээр нөгөө хувь хүний өөрсдийн мэдээллийн асуудал байгаа учраас энийг танд биечлэн болон бичгээр өгөхөд бэлэн байна аа. Гадаадад суралцах болохоор их өндөр үнэ төлбөртэй байх нь мэдээж ойлгомжтой. Гэхдээ мөнгө хүрэхгүй байгаа учраас та нарыг хасаж байгаа гэсэн ийм зүйлийг төрийн байгууллагын зүгээс хэлэх ч учиргүй. Энэ зарчимгүй явдал гэдгийг бол бид ч гэсэн тантай адилхан санаатай байна. Хамгийн гол нь бүрдүүлсэн материалууд мөн түрүүн миний хэлсэн энэ 2 жишээгээр ийм зүйлүүд гарсныг би хэлье. Энэ дээр бас манай ажлын хэсгээс тодруулж Ганцэцэгийн зүгээс хариулах зүйл байвал хариулаад явж болно оо

Л.Энхнасан: Зулпхар гишүүн асуултаа асууна 3 номер Ганцэцэг нэмж хариулна.

Д.Ганцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

2025 оны Засгийн газрын 215 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид дээр тавьж байгаа шалгуур үзүүлэлт хяналтын тоотой холбоотой өөрчлөлтүүдийг бид уг нь нэмж тусгаж өөрчилж орж ирсэн. Гол шалгуурууд бид нар хяналтын тоог уг нь тогтоохгүйгээр ер нь журмын шалгуур хангасан суралцагчдад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад буцалтгүй тусламж дэмжлэгийг олгох ийм зохицуулалтуудыг тусгаж орж ирсэн байгаа. Саяын 2025 оны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтэд нийтдээ 17 материал ирсэн. Үүнээс 4 суралцагчийн материал журмын шалгуурыг хангаж байсан учраас бид нэмэлт материалуудыг үзээд материалуудтай нь бид нар танилцаад 4 суралцагч дээр санхүүжүүлэлтийг суралцах шийдвэрийг баталгаажуулж гаргасан.

Л.Энхнасан: Дэгээрээ бол тодруулга байхгүй юм байна. Тэгэхээр Зулпхар гишүүн асуултаа асууна уу?

С.Зулпхар: Байнгын хорооны хуралдаан даргалагч Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Боловсролын яамныхны энэ өдрийн амар амгаланг айлтгая. 3 асуулт байна аа. Энэ дотор нөгөө суралцагчид тэтгэлэг олгох, зээл олгох, буцалтгүй тусламж олгох гээд нэг ийм 3 тусдаа ийм үйл ажиллагаа байх шиг байгаа юм. Тэгээд энэ дотроос нь гадаадад суралцаж байгаа оюутнуудад олгодог тэтгэлэг зээл, тэгээд энэ тэтгэлэг зээлтэй холбогдуулаад тодорхой нөхцөлөө тавьж байгаа шүү дээ.

Заримыг нь эх орондоо ирж тухайн мэргэжлээр ажиллах гэдэг ч юм уу. Энэ гэрээний хэрэгжилт ер нь ямаршуу байдалтай байгаа бол? Гадаадад суралцчихаад эх орондоо эргэж ирээд тухайн салбартаа тухайн чиглэлээр ажиллаж байгаа буюу гэрээнийхээ нөхцөлийг биелүүлж байгаа энэ байдал хэдэн хувьтай байдаг юм, ер нь зүгээр хэдэн хүн яваад, хэдэн хүн яг энийгээ биелүүлж байгаа юм гэсэн нэг ийм асуулт байна.

Яагаад энийг асуугаад байна гэхээр зэрэг зорилго нь бид чинь манай дотоодын салбарын хүний нөөцийг л бэлдэх зорилготой явуулчихсан. Тэгээд тэд нар маань зарим нь тодорхой шалтгаанаар яах вэ цаашаа явчихдаг учраас энийг тодруулъя гэж байгаа юм.

Хоёр дахь зүйл энэ гэрээнийхээ нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд ер нь ямар хариуцлага хүлээлгэдэг юм бэ? Тухайлбал энэ гадаадад суралцахаар явчхаад зээл авчихсан улсууд тэгээд тэрийгээ төлөөгүй явж байна гээд ийм нөхцөл байдал үүсээд байгаа шүү дээ. Энийг Батнайрамдал гишүүн ч гэсэн энийг нэг санаачлаад өнгөрсөн жилүүдэд нэлээн ярьж явсан. Тэгэхээр энэний энэ хариуцлага нь яаж хүлээгддэг юм. Энэ дээр та бүхэн бидэнд мэдээлэл өгөөч гэж байгаа юм. Цаашлаад ер нь зүгээр цаашдаа ер нь бид энэ тэтгэлэг зээл болон буцалтгүй тусламжтай холбоотой нийтлэг ер нь бодлогоо ямаршуу байдлаар авч явахаар та бүхэн бодож байгаа юм бэ? Энэ дээр тодруулга өгөөч гэж. Баярлалаа.

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Энэ тоо баримтуудыг манайхан бэлдэж байгаарай. Юуны хувьд бол тэр боловсролынхоо зээлийн сангийн шугамаар суралцаад гэрээнд үүргээ биелүүлээгүй хүмүүстээ бол гэрээний нөхцөлийн дагуу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй учраас суралцсан бүх зардлаа эргүүлэн төлөх ийм шаардлагатай. Бид өнөөдөр ингээд гэрээгээ бүрэн биелүүлээгүй ийм нөхцөл байдлыг бол шалгаж үзээд Монголбанкны мэдээллийн санд оруулсан байгаа. Тэр нь гадаадад сурч байсан уу, дотоодод сурч байсан уу хамаагүй. Дотоодод сурч байсан хүмүүсийн эргэн төлөлт 97 хувьтай сайн байдаг.

Гадаадынх нэлээн доогуур байгаа. Тэр тоог нь манай улсууд хэлээрэй. Ер нь бид энэ эргэн төлөлт дээр ААН-үүдтэй гэрээ байгуулж хуулийн фирмүүдтэй гэрээ байгуулж эргэн төлөлтийг сайжруулах ийм шаардлагыг тавьж байгаа. Нийтдээ 1 250 орчим тэрбум төгрөгийн тэтгэлэг олгодгоос бид бас энэ жилдээ 33 тэрбумыг өөрийн эргэн төлөлтөөр нь авах ийм үүргийг хүлээдэг. Энэ жилийн тухайд 8 дугаар сарын байдлаар ойролцоогоор 9 орчим бараг 10 орчим тэрбум төгрөг эргэн төлүүлсэн ийм нөхцөл байдалтай байгаа.

Цаашдаа энэ төлөлтийг сайжруулах энэ арга хэмжээг бол тасралтгүй аваад явна аа. Урьд нь суралцаад төгсчихсөн ийм хүмүүстэй холбоотойгоор миний урд байсан боловсролын үе үеийн сайдууд чөлөөлсөн ийм тохиолдол байдаг. Мянга гаруй хүнийг. Энэ чөлөөлсөн нь бол 2012 оноос хэрэгжсэн Дээд боловсролын санхүүжилтийн тухай хуульд хэрвээ чөлөөлсөн тохиолдолд Улсын Их Хурлын тогтоол гарч байж чөлөөлнө өө гэсэн ийм заалттай байсан нь тэр тогтоол нь хэзээ ч гараагүй. Тэгээд Дээд боловсролын хууль өөрөө шинэчлэгдээд 2023 оны 7 сарын 7-ны өдрөөс үйлчлэл нь эхэлчихсэн. Тэгэхээр энэ тогтоол гараагүй үед гарсан энэ зээлээс чөлөөлсөн энэ асуудлыг эргүүлэн сөхөж тавьж энийгээ хүчингүй болго гэсэн шаардлагыг АТГ-аас ирдэг. Гэхдээ энэ дээр 2 талтай хандах ёстой, судлах ёстой. Үнэхээрийн ирээд гэрээнд хүлээсэн үүргээрээ Монгол Улсдаа ажиллаад эх орныхоо хөгжил цэцэглэлтэд өөрийнхөө хувь нэмрийг оруулаад гэрээнд хүлээсэн үүргээ биелүүлээд явчихсан хүмүүсийг Улсын Их Хурлын тогтоолыг тухайн үедээ гаргах гэж хэд хэдэн удаа оролдсон боловч тухайн үеийн Улсын Их Хурал нь гаргаагүй явчихсан л ийм л юм байдаг.

Тэгэхээр энэ дээр гэрээний хөөн хэлэлцэх хугацаа эд нарыг тооцоод бид Засгийн газарт танилцуулж оруулсан байгаа. Энэ асуудлаараа дахин Засгийн газарт оруулахад бэлэн байна.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс тоо баримтыг нь хэн хэлэх вэ? 3 номер Ганцэцэг.

Д.Ганцэцэг: Журмаар бол гэрээний хэрэгжилтийг хагас жил тутамд хийж авахаар дүгнэсэн байгаа. Ер нь бол төгсөж ирснээсээ хойш бол орон нутагт 3 жил, нийслэлд 5 жил ажиллах ийм журмын зохицуулалтуудыг хийж явж байгаа. 2024 оны 12 сард бидний эцсийн гэрээний хэрэгжилтийн дүгнэлтүүд маань гарна. Бид нар шаардлагатай тохиолдолд энэ хэрэгжилтүүдийг дүгнээд гэрээ зөрчсөн тохиолдолд авсан нийт санхүүжилтүүдийг эргэн төлүүлэх үйл ажиллагаа маань хийгдэж явж байгаа. Одоо бол яг нарийн тоонууд нь над дээр нэгтгэгдэж ирээгүй байна. Зээлийн сангаас авчихъя. Зээлийн сангаас би авчхаад танд би холбогдох мэдээллийг нь хүргүүлье.

Л.Энхнасан: Тэгэхээр гишүүнд холбогдох мэдээллийг нь яг тэр тоо статистик мэдээ тоотоороо ирүүлнэ үү? Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу?

Үүрийнтуяа гишүүний тэр асуусан асуулт нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн политехник коллежид байгаа хүмүүсийн тэтгэлгийн асуудлыг дунд нь ингээд орхичхоод байна гэж би ойлгосон. Бид нар энэ тэтгэлгийн асуудлыг зөвхөн дээд, гадаад энэ тэр гэдэг яахгүйгээр Монголд яг хэрэгцээтэй нь юу байгаа юм бэ гэдэг тал дээр эргэж авч үзэх хэрэгтэй юм шиг байна гэж би ойлгож байна. Зөв үү гэдгийг асуумаар байна. Дээд гэж заасан учраас тэнд олгохгүй байна гэдэг тодруулж байна.

Хоёрдугаарт багш нарын нэг хүүхдийг сургана гээд гомдолд их ирэх юм, санал ирэх юм. Тэгээд найм, есхөн мэргэжил байж байдаг. Тэгээд бүүр тодруулаад харсан Монгол хэл бичгээр МУИС-д сурч байгаа хүүхдэд хүртэл тэтгэлэгт багтахгүй гээд оруулаад ирчихсэн. Тэгээд энэ чинь манай Монгол Улсын Монголын Боловсролын зээлийн сан. Гэтэл багшийн нэг хүүхэд нь нэг Монгол хэлийг багшаараа суръя гэж байхад нь хамрахгүй гээд нэг ийм юм тавьчхаад суугаад байх юм. Тэгээд энэ нөгөө хууль дагаад журам дагаад эрэлттэй мэргэжил гэдгийг хэн хийхгүй ингээд гацаагаад байдаг юм оо гэдэг дээр би тодруулж асуумаар байна, нэг.

Хоёрдугаарт энэ зээл төлөх асуудал дээр Их Хурлын тогтоол гараагүй гэж байна. Тэгээд гаргах ёстой юм бол гаргая л даа хэдүүлээ. Тэгээд энэ нь өөрөө цаанаа янз бүрийн ашиг сонирхлын зөрчил холбоотой гээд л хэл ам болоод энэнээс айгаад гаргаагүй юм шиг ингэж би ойлгосон. Ний нуугүй ярьж байгаад энийг чинь сурч ирээд ажиллаад үүргээ биелчихсэн ч хүн байж байгаа. Зарим нь бол яг нөгөө нэг ирээ ч үгүй нэг хүмүүс байж байгаа. Энийг хар цагаанаар нь ялгаад нэг талд нь гаргая аа. Би бол Байнгын хорооноос энийг нь гаргаад нэг талд нь гаргахгүй бол энэ боловсролын зээл дамжсан нэг түмэн хардалт хэрүүл ам болсон нөгөө манай Боловсролын зээлийн сангийн Сийлэгмаа хааччихсан. Мань хүнийг дарамтлаад ажлаас нь халаад баахан дарга цэрэг нар зээл төл гэхээр дарамтлаад байна гэдэг юмыг хэвлэл мэдээллээр мэдэгдсэн. Үгүй тэр хүн ажлаа хийж байгаагийнх нь төлөө зээл авсан хүмүүс нь дарамтлаад байна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Тэрэн дээрээ тулах юм ийм шударгаар ажиллаж байгаа төрийн албан хаагчаа хамгаална шүү. 30 тэрбумаас чинь 10 тэрбум л төлөгдсөн. 20 тэрбумаар чинь сурах ёстой маш олон хүүхдүүд сурч чадахгүй өнөөдөр ингээд дуусаж байгаа юм байна л даа. Жирийн айлын нэг 3 сая төгрөгийн зээл авъя гэсэн хүүхэд олдохгүй байгаа юм байна лээ шүү дээ. Наад боловсролын зээлийн сангийн мөнгө чинь. Зарим нь 300 сая, 400 саяар нь авна гээд явж байдаг.

Тэгэхээр наад боловсролын зээлийнхээ сангийн журам дээр эргээд авч үзвэл яг энэ дээр нь тэр хүртээмж тал руу нь нэг талаасаа анхаарахгүй бол болохгүй юм байна гэдэг тал дээр та бүхэнд санал байна уу? Яг журам дээр заасан зарим үг үсгийг Засгийн газраар орж ирэхдээ янз бүрийн байдлаар засагдсан байна лээ.

Тийм учраас энэ журам дээр хэрвээ нэмэлт, өөрчлөлт санал шаардлага байвал тэрэндээ өөрчлөлтийг нь оруулаад хийгээд явбал яасан юм бэ гэдэг ийм саналыг хэлмээр байна. Тэгээд одоо энэ зээл төлөөгүйгээс болоод хэчнээн хүүхэд сурах боломжоо алдсан бэ? 33 тэрбум гэдэг бол харьцангуй бага шүү дээ. 20 тэрбум төлөөгүй юм байна. Тэгээд энэ хүмүүс ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр тэр Улсын Их Хурлын тогтоол гараагүй гэдэг бол тэр 2023 онд Дээд боловсролын тухай хууль хэрэгжиж эхлэхээрээ тэр заалт угаасаа байхгүй болсон. Одоо бол тийм шаардлагагүй. Тэгэхээр зэрэг энэ асуудлыг хариуцаж байгаа байгууллагууд нь яг гэрээний биелэлтээ хараад ингээд Засгийн газраар оруулаад ингээд чөлөөлөх ийм боломжтой болсон гэсэн үг. Өмнө нь гарсан тушаал дээр бол иргэн энийгээ авч үзье гэсэн ийм шаардлага ирүүлээд байгаа ийм нөхцөл байдалтай байгаа. Сийлэгмаа даргын хувьд бол өнөөдөр ажлаа хийж байгаа. Дарамталсан зүйл бол байхгүй өөрөө янз янзын ярилцлага өгсөн байна лээ. Гэхдээ бид бас зээлийг эргэн төлүүлэхэд мэдээж анхаарч 3 ийм ажил хийж байгаа ч гэсэн өнөөдөр бол тэр зээлийн мэдээллийн санд нь нийлүүлчихсэн. Мөн 15 гаруй мянган иргэнд 2 удаа зээлийн мэдэгдэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Эргэн төлөлтийн хугацааг сая журмаар шинэчлэхдээ эргэн төлөлтийг 20 хүртэл жилээр сунгаж өгсөн. Өөрөөр хэлбэл өндөр төлбөртэй сургуульд сурсан хүн эргэн төлөх боломжийг нь илүү нээсэн гэсэн үг. Ийм байдлаар явж байгаа. Ажлууд нь явж байгаа. Гагцхүү зарим нэг асуудал үүсээд байгаа хэлэхээс өөр арга алга.

Өнөөдөр жишээлбэл Польшид сурч байгаа 92 хүүхдийг 4 сараас хойш тэтгэлгийн боловсролын зээлийн сан олгоогүйгээс болоод гудамжинд гарахаар ийм

хэмжээнд хүрчихсэн байх жишээтэй. Хариуцлага хаа хаанаа хэрэгтэй байна. Энийг л бид бас Боловсролын зээлийн сан дээр хариуцлага нэхэж байгаа ийм тал байгаа. Гэхдээ энэ бол дарамт биш ажил гэсэн л ийм л юм байгаа. Ажлаа бол хийгээд явж байгаа. Энэ ер нь бол эрэлтээ тэргүүлэх мэргэжлийг 5 жил тутам Засгийн газраас баталдаг. Энэ жил бол батлуулах жил нь болж байгаа. Тийм учраас бид өргөн барьж энэ эрэлттэй тэргүүлэх мэргэжил дээр Монгол хэлний багш өнөөдрийн бэлтгэгдсэн нөхцөл байдлыг судлаад оруулахад бэлэн. Багш нарын хүүхдийг нэг хүүхдийг нь 15-аас дээш жил багшилсан багшийн нэг хүүхдийг төрийн өмчийн дээд их дээд сургуульд үнэгүй сургана гэсэн ийм заалт байгаа. Энэ эрэлттэй тэргүүлэх мэргэжлээр гээд хуулийн заалттай юм аа. Тэрүүгээрээ л явж байгаа гэдгийг ойлгоорой.

Өнөөдөр бол багш мэргэжлээр суралцаж байгаа оюутан магистрантуудад олгох сургалтын төлбөр бол өнөөдөр бид нийтдээ суралцагчийн тоо бол 4230 байна. Тэгээд 13 тэрбум 941 сая төгрөгийг жишээлбэл энд зарцуулж байх жишээтэй.

Тэгэхээр бид энэ ялангуяа дотооддоо суралцаж байгаа суралцагчдад тэтгэлгийг ямар нэгэн байдлаар саатуулалгүй өгч байгаа. Гадаадад сурч байгаа нь өрсөлдөөн ихтэй байна.

Хоёрдугаарт өндөр үнэтэй байна.

Гуравдугаарт тэнд хэл ам ихтэй байна. Одоо яг 18 нас хүрчихсэн хүмүүсийн өөдөөс нь ээж аав нь л хэл ам хийгээд л яваад байх жишээтэй. Энэ чинь уг нь юуны хувьд бол эрх зүйн хувьд бие даасан улсууд шүү дээ. Ийм нөхцөл байдалтай л байна. Бүх зүйлүүд нь яг өөрсдийнх нь юугаар нь яваад яг манай гаргасан журмынхаа дагуу.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах юм, нэмж. Байхгүй байна. Галбадрах гишүүн асуултаа асууна.

Ж.Галбадрах: Энэ өдрийн мэнд хүргэе. Үүрийнтуяа гишүүн их зарчмын их зөв асуудал асуусан. Тэгээд тэрний сайдын хариулт энэ тэрийг ингээд уншаад танилцсан.

Энэ дээр ингээд нэмж асуух асуулт байна. Боловсролын зээлийн санд бид нар Батнайрамдал гишүүн ахлаад бид нэлээн хэлэлцэж яриад шинэ журам өөрчлөлтүүд оруулсан. Тэр шинэ журмын дагуу явж байгаа юу? Тэрүүгээр ямар нэг шинэ журамтай холбоотой асуудлууд хүндрэлтэй асуудлууд гарч ирсэн үү? Тэр тулгарч байгаа зүйл байвал энэ цаг үеийг ашиглаад хэлбэл зүйтэй байна гэж бодож байна. Эргэн төлөлтийн хувийг сая 97 хувь гээд дотоодод сурч байгаа нь 97 хувьтай байгаа гээд хэлчихлээ. Энэ үнэн үү? Үнэхээр яг энэ бодит ийм эргэн төлөлт нь ийм байгаа юу гэдэг. Бид нар чинь ийм байгаа шүү дээ. Боловсролын яамны төсөв дотор маань төсөвт бүрдүүлэх орлого дотор жишээлбэл энэ Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтөөс 145 тэрбум төгрөг орох ёстой гэж байгаа юм. Тэгээд 97 хувьтай. Гадаадад явснуудынх нь орж ирэх байх. Тэгээд 145 тэрбум төгрөг дотор хэдэн хувь нь эргэн төлөх өдөхөөр байгаа вэ? Энэ жишээлбэл энэ 2025 онд хэдэн төгрөг орж ирэхээс хэдэн төгрөг нь орж ирээд хэдэн хувьтай явж байна гэдгийг асууя.

Тэгээд ер нь гадаад, дотоодын зээлийн энэ сургалтын төлбөрийн зээл, хөнгөлөлт, тэтгэлгийн энэ нэг тоон харьцааг та бүхэн нэг хэлээд өгөөч. Тэгэхдээ оюутны тоогоор биш. Тэгэхээр цөөн болчхоод байдаг гадаад нь. Мөнгөн дүнгээр нь нэг харьцуулаад хэлээд өгөөч. Энэ ер нь зохистой харьцаа нь хэд байх ёстой юм бэ гэдгийг нэг мэдмээр байна. Дараа нь багшаар суралцагчдад олгох төлбөрийн хөнгөлөлт төсөвт хэдэн төгрөг туссан байсан бэ? Өнгөрсөн жил. Тэгээд тэр нь хэдэн хувийн биелэлтээс багшийн бид нар хөнгөлөөд байгаа шүү дээ сургалтын төлбөрийг нь. Тэдэн оюутан элсүүлээд тэдээр хөнгөлнө гэсэн нэг ийм тооцоо төлөвлөлт байж байгаа. Багшийг нь салгаж ярьж байгаа юм шиг. Би тэгээд энэ хэдэн хувийн биелэлттэй явсан юм ер нь. Энэ талын юмыг асууя. Зүгээр биелээгүй бол ямар байдаг юм. Эсвэл цаана нь багшаар сураад байгаа мөртөө хөнгөлөлтийг 100 хувь болгочхоод хөнгөлөлтөө эдэлж чадахгүй байгаа оюутан байна уу гэдэг энэ зорилгоор би асууж байгаа шүү. Нөгөө талаас бид нар тэр журамд оруулахдаа би санаа хэлж байсан. Тэгэхдээ тэр бүрэн тусаагүй байсан.

Өндөр оноотой хүүхдүүдийг бид нар багшийн мэргэжлээр сурах үед бүүр төлбөр хөнгөлөхөөс гадна цалинтай оюутан болох талын бодлого барья гэдэг саналуудыг оруулж байсан. Ингэж байж байж байж бид нар нэг 600-аас дээш ЭЕШ-д тухайн мэргэжлээрээ авсан хүүхдүүдийг оруулах, багшийгаа чанаржуулах гэсэн ийм юм байсан. Тэгээд энэ талын арга хэмжээ нэвтэрсэн үү гэдгийг асууя. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Наранбаяр сайд хариулна уу.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ дотоодын зээл гадаадад суралцагчдад олгосон зээл гээд 2024 оны байдлаар бол гадаад, дотоод зээл бол нийтдээ хөнгөлөлттэй зээл, оюутны хөгжлийн гээд ингээд явна. 363 сая байж байгаад оюутны хөгжлийн зээл нь 11 тэрбум 614 болж ингээд нэмэгдсэн. Энэтэй харьцуулахад бол гадаад суралцагчдад олгосон зээл нь бол 2 тэрбум 579 хүн. Энэ тоо зөв үү. Ийм нөхцөл байдалтай байна. Тэгэхээр ер нь бол бид энэ багшаар суралцаж байгаа оюутнуудад бол 2026 онд өргөн мэдүүлсэн төсвийн тоо нь 13 тэрбум 670 сая төгрөгөөр багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад төлбөрийн 100 хувийн хөнгөлөлтийг үзүүлэхэд зориулж ийм юу гаргасан. Эндээс өнөөдөр ингээд энэ зээл чинь бол аль 2014 оноос эхэлсэн. Эндээс эхлээд ингээд явсан энэ тэтгэлэг зээлүүдийг ингээд дүгнээд үзэхэд өнөөдөр багш мэргэжлээр суралцаж төгсчхөөд тэгээд багшаар ажиллаагүй 800 гаруй хүн байгаа юм. Тэднийг эргэж багшлуулах, багшийнхаа ажлыг хийлгэх эсвэл зээлийг нь эргүүлэн төлүүлэх ийм шаардлага тавьж байгаа.

Тэгэхээр өнөөдөр бол бид бас багш ажилтны хүүхдэд суралцагчдад 2.3 тэрбумыг баталчхаад байна. 10-аас 12 сард бол санхүүжилтээрээ хүлээгдэж байна. 2024 онд 571 суралцагчид 2 тэрбумыг олгосон. 2024 онд 9.7 тэрбум төгрөгийг энэ зээлд зориулж гаргаад нийтдээ гүйцэтгэл нь 99.6 хувьтай ингээд явж байгаа.

Тэгэхээр өнөөдөр гадаадад суралцагчдын зээл бол нийтдээ энэ нийт энэ зээлийн энэ Улсын Их Хуралд ноднин 2025 оны төсвийн тодотголоор бол 15 тэрбум, 325 сая байна шүү. Тэрнийхээ тоог уучлаарай хасъя. Тэгээд Ерөнхийлөгчийн тэтгэлэгт нийтдээ 53 тэрбум 17 сая гээд. Ингээд Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэгт бол 18 тэрбум 664. Ийм байдлаар явж байна. Тэгэхээр ер нь бол гадаадад суралцаж байгаа суралцагчдын нийт зээлд эзэлж байгаа хувь хэмжээ нь Ганцэцэгээ хэдэн хувь болж байна? 70 хувьтай явж байгаа. 30 хувь нь дотоодынх. Баярлалаа.

Л.Энхнасан: Нэмж ажлын хэсгээс гишүүний асуултад бүрэн хариулъя. 6 дугаар микрофон. Нэр албан тушаалаа хэлээрэй.

С.Должинсүрэн: Боловсролын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн 2025 оны төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сан дээр нийт 156 тэрбум төгрөг батлагдсан. Үүний 126 нь улсын төсвөөс, 30 нь эргэн төлөгдөх зээлээс санхүүжихээр төлөвлөгдсөн байгаа. Тэгээд 8 дугаар сарын байдлаар 30 тэрбум төгрөгийн эргэн төлөлт нь болохоор 13.3 тэрбум бөгөөд үүний 2.5 тэрбум төгрөг нь болохоор дотоодын хөнгөлөлттэй зээлээс, 8.4 тэрбум төгрөг нь болохоор оюутны хөгжлийн дотоод зээлээс, 2.6 тэрбум төгрөг нь болохоор гадаадад суралцагчдад олгосон зээлээс тус тус эргэн төвлөрүүлэлт хийсэн байна аа.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэболд гишүүн асуултаа асууна уу.

С.Эрдэнэболд: Үүрийнтуяа гишүүн маш чухал асуудал хөндсөн байна, бас талархал илэрхийлж байна. Яах вэ энэ Боловсролын зээлийн сантай холбоотой асуугаад байгаа зүйл дээр нэг хэдэн тодруулах зүйл байгаа юм. Тэтгэлэг гэж нэг яриад нэг явсан 2000 оноос хойш. Тэтгэлэг гэдэг чинь олон улсын хэллэгээрээ сколар шип буюу нэг удаа буцалтгүй. Ингээд Боловсролын зээл зээлийн сан гээд явчхаж байгаа. Зээл гэдэг чинь лөүн буюу буцааж төлөгдөх зүйл. Гэнгүүт энэ зээлийг аваад гэрээний үүргээ биелүүлээгүй. Гэрээний үүрэг гэдэг маань үндсэндээ нэг 3, 4 юм байгаа шүү дээ. Эхлээд орон сууц ч юм уу яг түүнтэй тэнцэхүйц үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавиад тэгээд яг тэр гэрээнд заасан сургуульдаа очоод бүрэн суралцаад Монгол Улсдаа хүрч ирээд гадаадыг нь би ярьж байгаа шүү. 5 хүртэлх жил төрд ажиллаад захиалагч байгууллагатай ажиллана шүү дээ. Эс үгүй бол яах вэ нөгөө хүний нөөцөд төрийн байгууллагад ажиллаж болж байгаа юм.

Ингээд 5 хүртэлх жил ажиллаад 5 хүртэлх жил ажилласны дараагаар Боловсролын сайдын тушаалаар ингээд зээлээс чөлөөлж байгаа. Ийм процесс явж байгаа тийм үү. Гэнгүүт энд яаж байна гэхлээрээ 1 дүгээрт 1 гэр бүлийн хэд хэдэн хүмүүс энэ зээлийг авчихсан байхаар энэ бол шууд шударга биш болчхоод байгаа байхгүй юу энэ чинь. Улс даяараа юу гэдэг юм ах дүү хамаатан саднаараа энэ зээлийг авчихсан гэдэг чинь бол шууд эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашигласантай хамааралтай зүйл болчхоод байгаа юм, нэг.

Хоёрдугаарт тухайн сургуульдаа гэрээгээр сурна гэсэн сургуульдаа сураагүй гэдэг нь нэг асуудал. Сурч төгсчхөөд ирээд 5 хүртэлх жил ажиллаагүй гэдэг нь дахиад нэг зөрчлийн асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр сая хэлж байх шиг байна. Яг энэ тохиолдлууд дээр бол зарим нь хуулийн асуудал явчхаж байгаа юм. Нэг гэр бүлээс хэд хэдэн хамаарал бүхий хүмүүс явчихна гэдэг энэ бол танил талаа ашиглаж авсан гэсэн логик нь харагдаж байгаа. Тэгээд гэрээний үүргээ биелүүлээгүй хүмүүсийн шууд тухайн үеийн долларыг энэ үеийн энэ чинь хориод жилийн өмнөхөөс эхэлж байгаа гэж тооцох юм бол одоогийн долларын ам.долларын ханштай харьцуулаад ингээд энэ хүмүүсийг шууд нэхэмжлээд ингээд шууд л явчихмаар байгаа юм, нэг.

Хоёрдугаарт гэрээний үүргээ биелүүлсэн байсан ч гэсэн ер нь боловсролын зээлийн сангаар сурсан гэдэг нь ЖДҮ хулгайлсан юм шиг, концесс хулгайлсан юм шиг, нүүрс хулгайлсан юм шиг улс төржилтийн сэдэв болчихсон. Тэгэхээр ер нь энэ дээрээ нэг мөр шийдээд ер нь зээл л бол зээл гээд энүүгээр суралцсан хүмүүсийг

гэрээний үүргээ биелүүлсэн ч гэсэн урт хугацаандаа лизинг гэдэг шиг буцааж төлүүлэх тийм шийдвэр гаргавал яадаг юм. Бараг тэр нь эрүүл шударга юм шиг байгаа юм. Зээл авсан бүх хүмүүс мөнгөө төлье өө гэдэг шиг. Тэгэхгүй болохоор энд нэг тийм хэмжих нэгжийн хувьд ялгаатай болчхоод байгаа юм. Энэ дээр Боловсролын сайд нэг байр сууриа хэлээч. Ямар ер нь бодлого барьж байгаа юм.

Л.Энхнасан: Баярлалаа Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ Эрдэнэболд гишүүний яг хэлээд байгаа үнэн. Одоо энэ зээлийн эргэн төлөлт дээр бол 5 жил ингээд Монголынхоо төрийн албанд зүтгээд ингээд явчихсан хүмүүсийг чөлөөлөх шаардлагатай, яг шударгаар ингээд яг л зориулалтаар нь хэрэглээд буцаж ирээд ажилласан. Гэтэл түрүүнд ярьсан тэр 2023 он хүртэл үйлчилсэн дээд боловсролын санхүүжилтийн тухай хуулиар нэг ийм заалт орсноос болоод тэр Улсын Их Хурлын тогтоол нь гараагүй үед ингээд чөлөөлчихсэн энэ чөлөөлөлтүүдийг яах вэ гээд судлаад үзэхээр бас гэрээний үүргээ биелүүлчихсэн хүмүүс ч тэр дотор байгаад байгаа юм. Нэг ийм юм байна.

Хоёрдугаарт тэгвэл бид энэ зорилго нь ер нь юу юм бэ? Гадаадад сайн хүнээ бэлдээд эргүүлж авчраад энэ авьяастай улсуудаа төрийн албандаа зүтгүүлж энэ төрийн албаа ийм чадвартай хүнээр ажиллуулъя гэсэн ийм зорил бодлого тавьсан юм шиг байгаа юм анхандаа. Тэгээд ирэхээр бид бас энэ эргэн төлөлт дээр энд ирээд авч байгаа цалин нь тэнд авах цалингаас хэд дахин бага байгаа шүү дээ. Тийм учраас төлөх чадвар нь эрс буурч байгаа юм.

Тийм учраас бид сая энэ 2025 онд энэ журмаа шинэчлэхдээ эргэн төлөх хугацааг 10 жил байсныг 20 жил болгож урт болгосон. Тэгээд ингээд төлөөд явж болно оо гэсэн ийм юуг өгсөн.

Хоёрдугаарт, нэг гэр бүлийн хүн сурахгүй байх гэсэн. Жишээлбэл нэг гэр бүлийн 2 хүүхэд юу гэдэг юм 2, 3 жилийн дараа дүү нь нэг сайн сургуульд шилдэг 20-д тэнцчихлээ гээд ингэхихээр энэ чинь хүний эрхийн зөрчил гараад байна гэсэн юмыг Хүний эрхийн Комиссоос ирүүлсэн. Тэгээд зарим тохиолдолд овог нь ижил салж сарнисан гэр бүлийн хүүхэд ингээд тэнцчихээр асуудал үүссэн ийм тал байсан. Тэгэхээр энэ дээр бас бид хүний эрхийг хангангаа хэрхэн одоо энэ хязгаартай нөөцөө олон гэр бүлд хүргэх вэ гэдэг асуудал яригдаж байгаа. Сүүлийн жилүүдэд бол энэ Ерөнхийлөгчийн тэтгэлэг бол илүү жин дарж байгаа. Бараг өгч байгаа 156 тэрбум төгрөгийн бид эргэн төлөлтөөсөө 33 тэрбумыг нь авах ёстой. Эндээс нь ингээд харахад бол үүний бараг 60 орчим 51, 52 тэрбум төгрөг нь Ерөнхийлөгчийн илгээлтээр явж байгаа энэ хүүхдүүдэд зориулагдаж байгаа. Ингээд ирэхээр энэ бол нэлээн би бол харахад Монголд өнөөдөр байж байгаа гадаадын их, дээд сургуульд тэнцдэг хүүхдүүдийн тип буюу энэ загварыг их өөрчилж байна гэж харж байгаа. Тухайн орон нутагтаа ахлах сургуулиа төгсөөд тухайн орон нутагтаа тогтвор суурьшилтай 3 жил ахлах сургууль дээрээ сурсан хүүхдүүд энд хамрагдаж байгаа. Тэгээд элсэлтийн шалгалтаараа номер нэгээр гараад ирчихсэн ийм хүүхдүүд.

Тэгэхээр энэ боловсролын зээлийн санг Монгол Улс даяар түгээх ийм төрийн өмчийн сургуульд суралцаж төгссөн ийм чадварлаг хүүхдүүд явахад нэлээн сайн нөлөө үзүүлээд байна уу гэж харж байгаа юм. Тэгэхээр бид бас бодлогын хувьд буцаан төлөвлөлт дээр яг одоо энэ гэрээний үүргээ биелүүлчихсэн хүмүүс дээр,

биелүүлээгүй хүмүүс дээр маш сайн судалж байж хийх ёстой юм байна гэж харж байгаа. Энэ бодлогын хувьд бол 20 жил болгож ингэж.

Л.Энхнасан: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүн асуултаа асууна.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Миний бие Наранбаяр сайдад 2025 оны 5 сарын 6-ны өдөр асуулга тавьсан. Асуулга маань 2 асуулттай. Үндсэн агуулга бол Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоол гарч үндсэндээ Монгол Улс бүсчилсэн хөгжлийн бодлогыг баримталж ажиллах энэ цаг хугацаанд орон нутагт ялангуяа инженерчлэлийн боловсролыг дэмжих цаашдаа олон мега төслүүд төслөө хэрэгжүүлэхэд боловсон хүчний бодлогыг хангах зорилгоор орон нутагт технологийн 3 сургууль байгуулах шийдвэр гарсан. Энэ тогтоолоор. Дарханд, Өмнөговьд, Эрдэнэтэд. Яг энэ тогтоолын дараагийн заалтаар орон нутагт сурч байгаа их, дээд сургуулийн оюутны сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлөх ийм шийдвэр гаргасан. Энэ шийдвэр нь үндсэндээ нэг талдаа мэргэжлийн инженерүүдийг бэлтгэх энэ боловсон хүчнийг бэлтгэх боломж, нөгөө талдаа орон нутгийн их дээд сургуулиудад дэмжлэг үзүүлэх ийм асуудал шийдсэн юм.

2021 он, 2022 он, 2023 онд энэ тогтоол хэрэгжсэн. 2024 оноос эхлээд хэрэгжүүлээгүй. Хэрэгжүүлэхгүй байхдаа энэ асуудлыг Боловсролын зээлийн сантай аваачиж хольж хутгасан хольж хутгасан. Дараа нь Боловсролын зээлийн сангийн журмаар тайлбарлаад амьжиргааны түвшинтэй уялдуулаад олгох боломжгүй гэж гэнэтийн шийдвэр гаргасан. Ямар ч урьдчилан мэдэгдсэн зүйл байхгүй. Төсөв нь батлагдчихсан тухайн жилд. Ийм асуудал үүслээ 2 хүчин төгөлдөр Засгийн газрын тогтоол хоорондоо зөрчилдөж байна гээд Их Хурлын гишүүний зүгээс тавихаар 2025 онд гаргасан шийдвэрээрээ энэ 2021 оны шийдвэрийг хүчингүй болгосон.

Би хүчингүй болгох шийдвэр гарахаас өмнө би асуулга тавьсан. Асуулгаараа 1 дүгээрт энэ асуудлыг шийдэх юм уу. Энэ зөрчилдөөд байгаа асуудлаа шийдэж энд 50 хувийн хөнгөлөлтийг цаашид олгодог болгох энэ зөрчлийг нь арилгах уу гэдэг асуудлыг тавьсан. Үндсэндээ гаргасан шийдвэрээрээ олгохгүй гээд хариулчав уу гэж би харж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр та надад албан ёсоор шийдвэр өгөөч. Энэ гаргасан хууль зөрчсөн шийдвэрээ өөрчлөх юм уу. Таны хариултаас шалтгаалж би энэ асуудлыг Улсын Их Хурлын чуулганд оруулах уу, эс оруулах уу гэдэг асуудал дээр шаардлагатай тохиолдолд биш санал хураалгах саналаа гаргах эрхтэй болж байгаа юм.

Тэгэхээр та энэ 321 дүгээр тогтоолын хүчингүй болгосон заалтаа хуулийн хүрээнд уялдуулан сэргээх үү үгүй юү гэдэг дээр тодорхой хариулт өгчих.

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна аа.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ 2021 оны энэ тогтоол бол төвлөрлийг сааруулах орон нутаг дахь их дээд сургуулийн сургалтыг дэмжихэд бол маш сайн үр нөлөө үзүүлсэн гэж боддог. 2023 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон Дээд боловсролын тухай хуулийн 4.1.7 дээр сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэж Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт болон

төлбөрийн чадамжийг харгалзан, төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг хэлнэ гэгчихсэн байгаа.

Тэгэхээр энэ хуулийн заалттай уялдуулж л дараа гарсан журмууд нь өөрөөр хэлбэл амьжиргааны түвшнийг нь харгалзана гэсэн ийм л журам руу орчихсон юм байна лээ л дээ. Төлбөрийн чадварыг харгалзан гэдэг энэ үгнээс болоод. Мэдээж сурлагын амжилтыг 2.8, 2.9-ийн голчоос дээш сурч байгаа орон нутгийн хүүхдүүд бол шууд энэ 50 хувийнхаа хөнгөлөлтийг бол эдлэх боломжтой. Мөн боловсролын зээлийн сангаас хүүгүй орон нутгийн сургуульд суралцаж байгаа хүүхдүүд бол зээл авах 50 хувь дээрээ зээл авах боломжтой байгаа.

Өнөөдөр яг энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын 50 хувийн хөнгөлөлт бол нийтдээ Дархан-Уул аймаг дахь салбарт бол 225, Орхон аймаг дахь салбар сургууль 61 гээд ингээд нийтдээ бол 1853 хүүхэд, 3 тэрбум 202 сая төгрөгийн ийм хөнгөлөлтийг эдэлж байгаа ийм нөхцөл байдалтай байгаа. Хуулийн энэ заалтыг хэрхэн тайлбарлах вэ гэдгээс их зүйл шалтгаалж байгаа. Боломжтой бол их дээд сургуулиа дэмжээд явах ийм юу дүүрэн байна, сэтгэл зүрх.

Өөрөөр хэлбэл орон нутагт байгаа энэ их дээд сургуулийг дэмжих нь шууд төвлөрлийг сааруулахтай, бүсчилж хөгжихтэй шууд холбоотой учраас гагцхүү саяын уншсан энэ заалттай холбоотойгоор Сангийн яам ч гэсэн энэ журам дээр саналаа ирүүлж энэ амьжиргааны түвшний асуудлыг бол голлож оруулчихаад байгаа юм аа. Ийм л нөхцөл байдалтай байгаа.

Улсын Их Хурлын гишүүний хувиар та өөрийнхөө бүрэн эрхийг хэрэгжүүлээд ингээд явахад бид хамтран ажиллахад бэлэн байна аа.

Л.Энхнасан: Тэгэхээр яг тодорхой асуусан. Яг тодорхой асуусан сайд тодорхой яг хариулбал зөв зүйтэй байна. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Хуралдаан даргалагчаа би тодорхой хариулсан шүү дээ. Маш тодорхой хариуллаа. Энэ 4.1.7 дээр ийм нэг заалт орчихоод байна аа. Суралцагчийн сурлагын амжилт болон төлбөрийн чадамжийг харгалзан төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг тодорхойлсон байдаг аа. Тэгэхээрээ та бол Улсын Их Хурлынхаа гишүүний бүрэн эрхийн хүрээнд энэ асуудлыг хөндөөд явахад бид бүхий л бололцоотойгоороо хамтран ажиллахад бэлэн байна л гэж хариулж байна.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс. Ажлын хэсэг 1 номер.

П.Оюунаа: Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал Оюунаа байна.

Би саяын Үүрийнтуяа гишүүний асуусан асуулттай холбоотой нэмэлт тодруулга хэлье гэж бодож байна. Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор Энх-Амгалан сайдад тодорхой үүрэг өгөгдсөн байдаг. Тэр нь болохоор орон нутаг дахь төрийн өмчит их дээд сургуульд суралцах оюутнуудад сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох асуудлыг холбогдох журамд нь тусгаж шаардагдах эх үүсвэрийг тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх ийм үүрэг өгөгдсөн.

Тэгэхээр энэ заалтаар бол яг энэ 50 хувийн хөнгөлөлттэй зээлтэй холбоотой асуудлыг холбогдох журамд нь тусга гэсэн ийм үүрэг өгөгдсөн байгаа. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад энэ 50 хувийн хөнгөлөлтийг олгох зээл, буцалтгүй тусламжийн энэ асуудлуудыг бол холбогдох журам буюу зээлийн сангийн журамд нь тусгаж өгсөн.

Л.Энхнасан: Гүйцээж хариулах уу.

П.Оюунаа: 321 дүгээр тогтоолоор өгсөн үүргийг хангаж, Боловсролын зээлийн сангийн журамд эдгээр хүүхдүүдэд 50 хувийн хөнгөлөлт олгох асуудлыг тусгасан байдаг аа. Тодруулга нэмж хэлэхэд.

Л.Энхнасан: Гишүүд асуулт асууж дууслаа. Зөвхөн асуулга тавьсан гишүүн үг хэлэх. Тэгэхдээ 5 минутаас илүүхэн хугацаанд үг хэлнэ ээ. Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгнө үү.

Д.Үүрийнтуяа: Өнөөдрийн асуулгаар би Монгол төрийн санах ой төрийн үйл ажиллагааны залгамж чанар, төрийн үйл ажиллагааны хурд энэ төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбооны асуудлыг хөндөж тавьж байгаа юм. 2021 оны 321 дүгээр тогтоолоор үүрэг өгсөн гэж та хэллээ Оюунаа. Яагаад тэгээд 2024 онд та нар журам гарч байгаа юм. 2024 оны журамд аваачиж хамаатуулж байгаа юм. Тэгвэл яагаад өмнө нь 2 жил журамгүй зардал гаргасан юм. Ийм асуудал үүсэх байхгүй юу. Та бүхэн 321-ийг үндэслээд 2 жил зардлыг нь гаргаад олгочихсон асуудлыг хөндөж тавьчих.

Олон хүүхдүүд, олон ар гэр, олон аав ээжүүд яг энэ нөхцөл байдалд уялдуулж амьдрал ахуй зардал мөнгөө төлөвлөсөн. Хөдөө орон нутгийн сургуулиудыг зорьж элссэн. Харамсалтай нь 2 дугаар курсээсээ эхлээд Монголын төрд Монголын боловсролын яаманд хулхидуулсан. Бодлого шийдвэргүй, уялдаа холбоогүй төрийн бодлогод хулхидуулсан. Нөгөө талдаа та бид хуулийг тайлбарлахгүй ээ.

Наранбаяр сайд миний асуулгад надад нэг хуудас материал ирүүлсэн. Яг тэр төлбөрийн чадамж гээд Дээд боловсролын тухай хуульд орсон өөрчлөлтийн сурлагын амжилт болон төлбөрийн чадамж гэж байгаа юм. Төлбөрийн чадамжийг Боловсролын зээлийн сангийн журамд юу гэж аваачиж уяж хаясан бэ гэхээр ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхийн суралцагч гэдгээр хязгаарласан. Төлбөрийн чадамж гэж ямар ойлголт юм хэн тодорхойлсон юм. Төлбөрийн чадамжгүй иргэн гэж ядуурлын шугамаас доогуур өрхийг хэлэх юм уу. Та нарын ойлголтоор бол энэ. Хэн ч тодорхойлоогүй. Ядуурлын шугамаас доогуур орлоготой өрх гэдгийг Нийгмийн халамжийн тухай хуульд халамжийн бодлогод хамруулах шалгуур болгож хэрэглэдэг болохоос биш боловсролын хүртээмжийн асуудлын шалгуур болгож хэрэглэхгүй. Тийм эрх та бүхэнд байхгүй.

Хуулийг ингэж тайлбарлах эрх та бидэнд байхгүй. Дээд боловсролын тухай хуулийн 4.1 таны хэлээд байгаа сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг сургалтын амжилт төлбөрийн чадамжид тулгуурлан суурилна гэсэн өргөн хүрээний уян хатан хуулийн зохицуулалтыг та бүхэн төлбөрийн чадамжийг ядуурлын шугамын доогуур орлоготой өрхөд хамааруулан нарийвчлан хязгаарлан тодорхой бүлэг хүмүүсийн ард иргэдийн эрх ашгийг зөрчиж хууль зөрчсөн шийдвэр гаргасан.

Хоёрдугаарт. Боловсролын үйл ажиллагаа тэгш, хүртээмжтэй, иргэнд ойрхон байх ёстой. Энэ төрийн бодлоготой та бүхний гаргасан шийдвэр зөрчилдсөн.

Гуравдугаарт. Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн үндсэн чиглэлд тусгасны дагуу иргэн бүрд чанартай боловсролыг бид хүртээмжтэй олгох ёстой. Нөгөө талдаа бүсийн төв, аймаг орон нутаг дахь их дээд сургуулиудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх үүрэгтэй. Мөн шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан ААН-үүдийг цогц бодлогоор дэмжиж төвлөрлийг сааруулах үүрэгтэй. Энэ Засгийн газрын 321 дүгээр тогтоол бол Дээд боловсролын тухай хууль болоод Засгийн газрын мөрийн хөтөлбөр Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэл, алсын хараа, энэ урт хугацааны бодлоготой уялдсан ийм шийдвэрийг та бүхэн харалган байдлаар хүчингүй болгосон.

Энэ бүх бодлогын зорилтуудынхаа эсрэг ийм шийдвэр гаргасан. Яагаад Монгол төрийн бодлого хоёрхон жилийн настай сайд солигдох санамжтай байх ёстой юм бэ. Яагаад та бүхний хэрэгжүүлж байгаа уялдаа холбоогүй бодлогоос чинь болж ард иргэд, ард түмэн, хүүхдүүд хохирч байх ёстой юм бэ. Яагаад тогтворгүй бодлогын чинь үр шим горьг ард иргэд хүртэх ёстой юм бэ? Дээр нь та бүхний гаргасан шийдвэр Дээд боловсролын тухай хуультайгаа нийцээгүй. Ялгаварлан гадуурхсан Үндсэн хуулийн зөрчилтэй.

Тийм учраас би санаачилгаараа энэ асуудлыг хөндөөд шийдчих болов уу гэж боловсролын сайдыг би багагүй хугацаанд энд сүүлийн хэдэн сар харлаа. Та Ариунболд гэж нэг газрын даргыг яриулсан. Тэр хүн таны саналыг бид нар шийдэж байгаа шүү гэсэн. Би санал тавиагүй, би асуулга тавьсан. Тэгж хэлэнгүүт утсаа таслаад алга болсон. Ийм учраас би санал хураалгамаар байна. Энэ асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх саналыг хурааж өгөхийг хүсэж байна.

Л.Энхнасан: Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор олонхын саналаар асуулгын хариуг бол нэгтгээд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно дэгээрээ. Тийм учраас санал хураалт хийе ээ.

Бүхэлд нь үү? Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагаас Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн нэр томъёогоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалтдаа бэлдэнэ үү.

Санал хураалт.

Санал хураалтад орсон уу? Рэгдэл гишүүн оролцоно уу. Санал хураалтад. 38.1 хувиар бол санал дэмжигдсэнгүй. Тэгээд Наранбаяр сайд хариулаад бичгээр та.

13.30 цаг

Ингээд дараачийн асуудалдаа оръё. **Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболдоос боловсролтой монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсэг ч юм уу тийм. Өмнө байсан ажлын хэсэг. Наранбаяр сайд Боловсролын сайд Нарангэрэл Мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Цогзолмаа Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Должинсүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бат-Эрдэнэ Цахим боловсрол, статистик мэдээллийн хэлтсийн дарга. Оюунаа Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, Бадамжав ахлах шинжээч, Нарантуяа ахлах шинжээч, Чойсүрэн шинжээч, Батсэлэм шинжээч, Ганцэцэг мэргэжилтэн.

Боловсролын сайд Наранбаяр асуулгын хариуг танилцуулна аа.

П.Наранбаяр: Минут хэдэн минут билээ? Сая нэлээн тасраад байсан.

Л.Энхнасан: 3 минут.

П.Наранбаяр: Тэгвэл жоохон товчилж ярья энэ эхний асуулга бол Үндсэн хуульд заасан сурч боловсрох, боловсролыг төлбөргүй болгох, төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулах гэсэн асуудалтай холбоотой ийм асуулга байсан. Үндсэн хуульд бол сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй болгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гэж заасан. Бид бас энэ Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан боловсролын багц хуулиуд байгаа. Энд тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байх зарчмыг баримтална гэсэн. Уг хуулийн 38.5.1-д бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гээд. Тэгээд энэ гүйцэтгэлд нь үндэслэн олгохоор ингэж заасан. Юнейскогоос эрхлэн гаргасан боловсрол эзэмших эрх гарын авлагад сурч боловсрох эрхийг хөндсөн эрх зүйн баримт бичгийг үнэлэх 4 А аргачлалын дагуу үнэлж хэлэлцүүлж байсан. Энэ Боловсролын ерөнхий хуулийн төслийг. Өнгөрсөн хичээлийн жилд бол нийтдээ төрийн бус өмчийн 640 боловсролын сургалтын байгууллагад энэ нь болохоороо цэцэрлэг, сургууль хоёроо нийлүүлсэн тоо. Энэ дээр 186778 суралцагч боловсрол эзэмшиж байна. Энэ нь бол нийт суралцагчдын бараг 15 хувийг эзэлж байна аа.

Засгийн газрын 2024 оны тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 53 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар хувьсах зардлын хэмжээг нь өөрчилсөн. Энэ дээр бол төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн байршлаас хамгаалах итгэлцүүр болон төрийн бус өмчийн ЕБС-ийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүрийг баталсан. Засгийн газрын тогтоолд заасны дагуу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ЕБС-ийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамааран дараах байдлаар итгэлцүүрээр санхүүжилт олгож байгаа.

Үүнд төлбөргүй болон 1 сая хүртэл төгрөгийн төлбөртэй нэгээр үржүүлж 1-ээс 5 сая хүртэл төгрөгийн төлбөртэй 0.6 -аар үржүүлж, 5-аас 10 сая төгрөг хүртэл төлбөртэй бол 0.5 гэсэн итгэлцүүрээр бодож байгаа.

10 саяас дээш төгрөгийн төлбөртэй бол 0 буюу хувьсах зардал олгохгүй байгаа. Бас мөн Боловсрол шинжлэх ухааны сайдын ноднин жилийн 2 дугаар сарын 9-ний өдөр гаргасан журам аргачлал байдаг. Энэ дээр бол ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг тэгш хамран сургахтай холбоотой шалгуурыг тусгасан. Энэ аргачлалын дагуу бол бид үр дүнгийн үнэлгээг нь үндэслээд гүйцэтгэлийн үр дүнг санхүүжүүлэх хувь хэмжээг.

Л.Энхнасан: Нэмж 2 минут.

П.Наранбаяр: Ингээд тогтоосон байдаг. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 189 сургуулиас 166 сургуульд нь хувьсах зардлын санхүүжилтийг олгож байгаа. Ингээд энэ гүйцэтгэлээр нь ингээд явдаг ийм санхүүжилт байгаа. Боловсролын яаманд 2024-өөс 2025 оны хичээлийн жилд иргэдээс төрийн бус өмчийн ЕБС-ийн багшийн ёс зүйн зургаа, сургалтын орчны аюулгүй байдлын 1, суралцах эрхийн 13 буюу сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, хохирох, эрүүл мэнд хохирох, дарамт ялгаварлан гадуурхалтад өртөх зэрэг агуулга бүхий нийт 20 өргөдөл гомдол ирсэн. Эдгээрийг бол хуулийнх нь хүрээнд нийт хяналт шалгалт хийж 10 байгууллагыг хамруулаад Зөрчлийн тухай хуульд холбогдох заалтыг үндэслэн 2 байгууллага нэг албан тушаалд шийтгэл ноогдуулж, зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 6, 3 сургуулийн захиралд улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг үүрэг даалгавар өгч гомдол гаргасан 8 иргэдэд тус яамны албан бичгээр хариу хүргүүлж шийдвэрлэсэн.

Салбарын хэмжээнд боловсролын сургалтын байгууллагын орчин дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.2-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнтэй холбоотойгоор Боловсролын сайдын А 121 дүгээр тушаалаар 2024 оны боловсролын салбарын хүүхдийн эрхийг хангах үүнтэй холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгжилтийг хангах дэд зөвлөл байгуулагдсан.

Мөн 2024 оны Засгийн газрын 53 дугаар тогтоолын хавсралтаар баталсан сургуулийн өмнөх ерөнхий боловсролыг эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд хүүхэд хамгааллын зардлыг багтаан олгож байна аа.

Хоёр дахь асуулт орчин үеийн шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжлийн эрин үе дэх нийгмийн болон бие хүний хөгжилтэй холбоотой ийм цогц асуулт байсан.

Бид бол энэ алсын хараа мөн 2020-2024 оны Засгийн газрын эрдэм боловсролтой Монгол хүн хөтөлбөр, 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг боловсруулъя гэдэг.

Л.Энхнасан: Нэмж хариулъя. Дэгээрээ 2 минутаа өгчихсөн. Тийм болохоор асуулт асуусны дараа тийм нэмээд хариулъя. Ингээд асуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Галбадрах гишүүнийг нэмье. Ингээд Зулпхар гишүүн асуултаа асууна уу?

Л.Энхнасан: Эрдэнэболд гишүүн их чухал асуудлаар их өргөн хүрээнд их тодорхой асуулгууд тавьж тэрнийхээ хариуг авч байгаа нь их чухал байна. Цаг үеэ ч олж байна. Ер нь байнга л ярьж байх ёстой асуудал учраас бид ер нь ойр ойрхон энийг ярьж байх гэж бодож байна. Цаашдаа Байнгын хороо холбогдох Дэд хороогоор. Надад ийм 2 тодорхой асуулт байна.

Нэгдүгээрт энэ нөгөө хүүхдийн эрх боловсролтой холбоотой хангачихсан байх тал дээр нэг чухал бидний нэг чиг үүрэг байгаа шүү дээ. Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал гээд.

Тэгэхээр энэ жилийн төсөв дээрээс бид яг тэр та сая бас хэлж байх шиг байна. Хүүхэд хамгааллын зардлыг тусгасан гээд байна шүү дээ. Тэгэхээр яг ямар ямар үйл ажиллагаанд нийтдээ хэдий хэмжээний энэ хүүхэд хамгааллын жишээ нь зардал болгоод төсөвлөчихсөн байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна гэж байгаа юм

Хоёр дахь зүйл их тийм тодорхой асуудал танай руу 2024 оны 10 сарын 18-нд явуулсан юм бичиг. Тэгээд бичгийн хариу маань яах вэ хараахан ирээгүй байгаа. Гэхдээ яах вэ бичгээр бид хариу авч байсан юм. Тэр нь юу гэхээр зэрэг сая энэ Эрдэнэболд гишүүний асуусан яг 4 дэх асуулттай яг таарч байгаа байхгүй юу. Багш нарын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг хангах гээд. Тэгээд энэ дээр сургуулийн эрхлэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой нэг ийм журам байгаа. Ер нь бол сургуулийн багш, цэцэрлэгийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалттай холбоотой. Энэ журам дээр нэг эрх тэгш байдлыг алдагдуулсан нэг ийм зохицуулалт байгаад байгаа юм. Тэрийг та хэд минь өөрчилнө гээд, өнгөрснөөс хойш ер нь өөрчлөөгүй л яваад байна. Бүтэн жил болчихлоо л доо.

Юу гэхээр зэрэг тухайн цэцэрлэгт арга зүйч хийж байсан хүн, эрхлэгчийн сонгон шалгаруулалтад орох гэхлээр зэрэг заавал багш хийсэн байх ёстой ийм хуулийн заалттай. Энэ хуульд тэгээд орчихсон юм байна лээ. Тэгсэн нөгөө хүн чинь бол угаасаа арга зүйч хийгээд байдаг тэр чинь нөгөө багш нартаа арга зүйгээр удирддаг хүн шүү дээ. Тэгсэн мөртөө эрхлэгчийн сонгон шалгаруулах шалгаруулалтад орж чадахгүй нэг ийм нөхцөл байгаа. Энийг журмаараа зохицуулна гэсэн. Тэгээд энийг та хэд маань яах юм бэ гэж байгаа юм. Тэгэхгүй бол энэ дээр маш том хүний сонгон шалгаруулалтад орох эрх зөрчигдөж байна. Хүний шатлан дэвших, өөрийгөө хөгжүүлэх, цаашлаад энэ чинь цалин хөлс нэмж авч болох энэ боломж шүү дээ. Тэгээд ч боловсролын салбарт өөрийнхөө мэдлэг чадварыг хувь нэмрээ оруулах ийм зорилготой үйл ажиллагаа. Энийг та хэд маань энэ журмыг хэзээ өөрчлөх вэ гэсэн нэг ийм асуулт байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Наранбаяр сайд хариулна уу.

П.Наранбаяр: Энэ чухал асуудал хөндөж байна аа. Зулпхар гишүүндээ талархал илэрхийлье. Ер нь бол энэ ерөнхий боловсролын хүүхэд хамгааллын зардалд бид 4.3 тэрбум, СӨБ дээр нийтдээ нэг 3.1 тэрбум төгрөгийг 2026 оны төсөвт яг хүүхэд хамгааллын чиглэлээр нь оруулж ирсэн. Ийм нөхцөл байдалтай байгаа. Хүүхэд хамгаалал дээр бас их чухал зүйл сургуулийн зөв соёл төлөвших явдал байдаг. Тэрэн дээр нийгмийн ажилтны чадвар, нийгмийн ажилтны оруулах сэтгэл энэ их чухал байдаг. Анги даасан багшийн багийн хамтын ажиллагаа гэх мэт ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр ер нь хүүхэд хамгаалал бол зөвхөн бас сургуулийн ч асуудал биш. Гараад ирэх юм бол хорооны, эцэг эхийн тухайн байрны гээд ингээд

томроод явдаг. Тэгэхээр энэ мөхлөгт нь бол сургууль оршдог оо, тэгэхээр ийм учраас бид энэ хүүхэд хамгааллын энэ зардлыг оруулж ирж Хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ийм зорилт тавин ажиллаж байна. Хичээлийн эрхлэгч болоод, өшөө цэцэрлэгийн эрхлэгч болоод сургуулийн захирлууд дээр ийм тавигдаад байгаа. Боловсролын ерөнхий хуульд өөрт нь орчихсон ийм нэг заалт байгаад байгаа юм. Энэ бол жишээлбэл захирал дээр гэхэд 6 жил заавал багшилсан байх, 4 жил удирдах ажил хийсэн байх нийтдээ 10 жил.

Гэтэл ингээд орон нутаг руу яваад ирэхээр яг энийгээ хангах хүн их ховордоод ирдэг юм. Нөхцөл байдал хүнд байгаа шүү дээ тэр таны яг цэцэрлэгийн эрхлэгч дээр тийм байна. Над дээр тодорхой тохиолдож байсан юу бол сургууль төгсөөд маш сайн дүнтэй төгссөн учраас эхнээс нь тэр үед хичээлийн эрхлэгч одоогоор менежер ингээд хийлгэгчигдсэн. Олон жил хичээлийн эрхлэгчээ хийгээд захирлыг ч олон жил хийчихсэн хүн түр өөр салбарт ажиллаж байгаад эргээд орж ирье гэхээр 10, бараг 20 жил захирал хийчихсэн хүн ингээд ороод ирье гэхээр багшаар 6 жил гэсэн таслал гэгчихсэн. Энэ хуулийн заалт нэг ийм нөхцөл байдлыг үүсгээд байгаа нь үнэн.

Түүний зэрэгцээ энэ яг хичээлийн цэцэрлэгийн эрхлэгч дээр арга зүйч зүйчээр ажиллачихсан хүнийг заавал багшилсан байх ёстой гээд. Тэгэхээр энэ дээр бол яам энэ журам дээрээ ажиллаж байгаа. Тэгээд боломжтой Хуулийн хэлтсээсээ бид хуулийнхаа хуулийнхнаасаа дүгнэлтээ авсны дараа энэ журмаа гаргаж ажиллана аа. Ингэж жоохон уян хатан болгож авахгүй бол энэ асуудал өөрөө өнөөдрийн боловсролын салбарт чадварлаг хүнийг олж ажиллуулахад ихээхэн хэцүү байдалтай байгаа юм. Ер нь энэ заалтыг ингэж хатуу зааж оруулж ирсэн энэ хуулийн төслөө ч гэсэн бид яах вэ энэ 2023 онд ингээд дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа хуулийг ахиад л өөрчилье эд нар гэдэг бол өөрөө боловсролын энэ хуулийг амилуулах хэрэгтэй эхлээд ашиглах хэрэгтэй. Ингэж явж байж бид нар болж байна болохгүйгээ сайн ярилцаж байж хийх ёстой.

Тэрнээс биш жил болгон хууль өөрчилнө гэж юу байх вэ. Жил болгон энэ хуулийн өөрчлөлт ярина гэж болохгүй. Гэхдээ тэр утгаар нь харах юм бол бид амилуулах, ажиллуулах энэ үүднээс нь харах юм бол энэ заалт маань зарим нэг тал дээр.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн асуултаа асууна.

С.Эрдэнэбат: Чухал асуулга тавьсан Эрдэнэболд гишүүнд баярлалаа.

4 дүгээр асуудалтай нь холбоотой би тодруулж асуумаар байна. Бид нар ингээд нөгөө багш нарынхаа цалин, нийгмийн асуудал гээд явж явж энэ цалин хөлс чинь л гол түлхүүр асуудал болчихоод байна л даа. Нийт шинээр орж байгаа багшийн бараг тал нь шахуу нь эхний 5 жилдээ буцаад гараад явчхаад байгаа юм байна. Тэгэхээр бид нар яах вэ гэхээр маш их төрийн мөнгө, цаг хугацаа зарцуулж бэлдсэн боловсон хүчнийг ингээд алдчихаад байна. Тэгэхээр одоо энэ дээр яах вэ гэж. Тэгэхээр энд энэ тал дээр 1 дүгээрт энэ цалин хөлснийх нь асуудал дээр та уул нь 560 орчим тэрбум төгрөг Сангийн сайд руу оруулсан юм байна лээ. Нөгөө сайд нь ёстой тийм боломж байхгүй гээд суучхаад байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газрын кабинетын зарчмын хувьд бол ийм эсрэг тэсрэг байр суурьтай байгааг би гайхаж байна л даа. Тэгээд маргааш багш нар ажил хаялт

хийнэ гээд байдаг. Тийм учраас энэ тал дээр бол манай Ерөнхий сайд бол сая 850 орчим мянган төгрөг эхний 1 сарын 1-ээс ингээд шийдчихье гээд би амлачихсан гэж ойлгосон. Тэгэхээр энэ асуудлаа нэг тодорхой болгох хэрэгтэй байна аа. Тэгээд энэ тал дээр бас энэ цалинг ер нь цаашдаа манай улсын энэ багш нарын хэдэн хувьд хүргэхэд яг ямар дэс дарааллаар хийх вэ гэдэг ийм бодлого байгаа юм бэ, нэг.

Хоёрдугаарт ерөөсөө орон сууц гэдэг аягүй чухал юм байна. Багш нар яагаад гадагшаа яваад ингээд байна вэ гэхээр хөөрхий нэг 10, 20 жил ажиллаад ч би ер нь орон сууцтай болохгүй юм байна. Тэрний оронд нэг гадагшаа яваад нэг ганц жил ч гэсэн ажиллаад явъя гэдэг л ийм л юм байна л даа. Тэгэхээр ер нь нэг 5 жил ажилласан багш орон сууцад орох эрхээ авдаг. Цаашаа дахиад 10-аас 15 жил дор хаяж тэр төрдөө ажиллах ийм одоо нөхцөлтэйгөөр ямар нэгэн урьдчилгаа болзолгүйгээр ингээд орон сууцтай болдог. Энэ бодлогыг хийхгүй бол орон сууцын асуудал Барилгын яамны асуудал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд оччихсон байгаа.

Тэгээд ингээд орхиод байхаар ерөөсөө болохгүй байна аа. Тэгэхээр хүний нөөцийн асуудал дээр манай боловсролын яам маань энэ тал дээр яг ямар ойрын хугацаанд энэ орон сууц нийгмийн асуудал дээр шийдэх төлөвлөгөө бодлого байна вэ? Дараагийн нэг аягүй чухал асуудал. Англи хэлийг 3 дугаар ангиас нь сурна гэсэн. Улсын хэмжээнд зуухан сургууль нэг англи хэлийг заах хэмжээний л байгаа юм байна лээ. Үлдсэн 600 сургууль бараг байхгүй. Тэгэхээр энэ боловсролынхоо зээлийн сангийн тэр үнэтэй нэг хүний 200, 300 сая төгрөгөөр сургадаг юмаа түр зогсоогоод энэ багш нараа хүүхдүүдэд тэгш гараанаас гарах боломж олгох үүднээс энэ багш нарыг бүгдийг нь тэр англи хэл сургах юманд нь явуулмаар байна аа. Энэ тал дээр нэг жоохон та зоригтой асуудлаа тавиад ажиллаач ээ.

Бид нар нэг их гадаадад Харвард, Оксфордод 1, 2 хүүхэд сурсан сураагүй нэг их тийм айхтар улс хохирчихгүй байх. Харин хэдэн 100 мянган хүүхдүүд англи хэлийг бусадтайгаа ижилхэн түвшинд сурах боломж алдагдаад байна. Хуульд оруулаад өгчихсөн. Одоо яах вэ гэхээр тэр хүүхдүүдийг сургах боломжийг бид нар дараа дараагийнх нь арга хэмжээг зоригтой дорвитой хиймээр байна аа. Энэ тал дээр яг ямар бодлого байна вэ?

Л.Энхнасан: Баярлалаа Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ цалингийн асуудал өнөөдөр хурцаар тавигдаж байна аа. Бид бас энэ тооцооллыг хийгээд Сангийн яамаар дамжуулаад ер нь засагтаа хэлсэн, оруулсан, танилцуулсан. Харамсалтай нь өнөөдрийн урсгал зардлыг нь нөхцөл байдал хэцүү байна гэдэг утгаар энэ маань бүрэн хэрэгжээгүй байгаа. Эхний ээлжид 100 тэрбум төгрөгөөр багш нарын цалинг нэмэгдүүлье гээд.

Бидний хийсэн тооцоогоор нэг 25 хувь өсгөхөд бид энэ цалингийнхаа энэ өсөлт нэмэгдлийг яаж хийх вэ, нэмэлтийг яаж хийх вэ гэхээрээ цалингийн бүтцийг эхлээд ухаалаг болох ёстой юм байна. Цалингийн бүтцийг их шударга байлгах ёстой юм байна гэдэг утгаар нь хэлж байгаа юм. Таны хэлдэг үнэн. Эхний 5 жилдээ багшилчхаад эхний үндсэн цалин ялангуяа нийслэлд байвал ямар ч орон нутгийн нэмэгдэл байхгүй.

Сая 483 мянган төгрөгийн үндсэн цалингаар 5 жил ажиллачихаар чинь хүн яаж ч яахгүй энэ салбартаа байж чадахгүй яваад өгч байгаа нь үнэн. Тэгэхээр бид

энэ үндсэн цалинд нь нэмэгдлүүдийг шингээх энэ бүтцийн өөрчлөлтийг хийх нь зүйтэй байна аа. Түүний зэрэгцээ багш нарынхаа үндсэн цалинг ер нь бодитой орлогыг нь 25 хувиар эхний ээлжид нэмье гэсэн ийм юм тавьж байгаа. Энэ дээр нийтдээ 560 орчим тэрбум төгрөг хэрэгтэй юм байна аа.

Ерөнхий сайдтай, Сангийн сайдтай уулзуулж гадаа суулт хийж байгаа багш нарын төлөөллийг уулзуулахад бол 2.5 сая ирэх жилийн 7 дугаар сараас эхлэхэд хүртэл энийг нэмэгдүүлэх боломжийг ярилцъя, судалъя. Тэгээд энийгээ шийдье гэсэн байдлаар энэ Улсын Их Хуралд ажлын хэсэг байгуулаад энэ дээрээ ярилцаад явъя гэсэн ийм нөхцөл байдалтай байгаа. Бид бас энэ өнөөдөр орж ирж байгаа орлого, цалингийн өөрийнх нь үндсэн энэ эдийн засгийн нөхцөл бололцоог хангаад бүхий л чадлаараа нэмэх ёстой гэсэн энэ байр суурь дээр байгаа.

Өнөөдөр Монголын олон багш нар цалингаа нэмэхийг хүлээж байгаа нь энэ цалингийн нэмэгдэл нь жил жилд ер нь бага багаар нэмсээр байгаад өнөөдөр энэ инфляцаа ч гүйцэхгүй ерөнхий амьдралын зардлаа ч ер нь гүйцэхгүй ийм нөхцөл байдалд хүрчхээд байгаа нь бодитой учраас энэ дээр нэг багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг өнөөдөр багш, эмч гэдэг бол энэ төрийн үйлчилгээний голыг нугалж байгаа улсууд. Мөн бусад төрийн албан хаагчид ч гэсэн төрийн үйлчилгээг хүргэж байгаа. Энэ улсуудтайгаа ингээд яг ийм цогц байдлаар нь нэмэх шаардлагатай байна гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгээд бид бас энэ Улсын Их Хурал дээрээ ярилцаад энэ нэмэгдлүүдийг энэ эх үүсвэрүүдийг хамтран ярилцаад тавьж чадна гэсэн ийм одоо итгэл үнэмшил байна. Бид бас энэ шууд юугаар ажил хаяхдаа биш, ярилцаж бодитой шийдлүүдээ ярилцах ийм боломж байсаар байгаа гэдгийг хэлье ээ.

Ипотекийн зээлийн тухайд энэ 5 дахь жилээс нь эхлээд төрөөс ийм шууд орон байраар хангаж ипотекийн зээлээр хангадаг байх нь зүйтэй. Бидний хийсэн судалгаагаар бол өнөөдөр 80-аас дээш метр квадратад олгоод байгаа.

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя. 80-аас дээш метр квадратад олгоод байгаа энэ ипотекийн зээл нь хэд байлаа? Должинсүрэн. Нийтдээ энэ нэлээн 1.2 их наяд байсан байх аа. Миний яг санаж байгаагаар. Энэ ипотекийн зээлээр олгогдож байгаа энэ зээлүүдийг ер нь үндсэн энэ ипотекийн зээлийг цэвэр арилжааных нь банкны юу руу оруулаад ипотек руу энийг оролцуулахгүй байж энэ дээр ингээд ирэх юм бол ер нь жилдээ нэг мянга орчим багш төрийн албан хаагчдын энэ ипотекийн зээлийг шийдвэрлээд байж болохоор эх үүсвэр харагдаад байгаа юм. Энийг Засагт хэлж танилцуулсан.

Гуравдугаарт нь Боловсролын зээлийн сан дээр байгаа энэ санхүүжилтийн эх үүсвэрийг бид энэ англи хэлний багшийг бэлдэхээр зоригтой ийм хэрэгжүүлэхээр энэ эхний чиглэл нь гараад явж байгаа. Энэ юу гэсэн үг вэ гэхээр энэ жилдээ бид нэг 300 англи хэлний багш, бага ангийн багшийг гадаадад бэлдчихье 1 сарын хугацаагаар.

Л.Энхнасан: Гүйцээгээд хариулъя.

П.Наранбаяр: Уучлаарай. Саяын тоонд бол 80 м2-аас дээш талбайтай орон сууцыг 8421 зээлдэгчид нийтдээ 1.8 их наяд төгрөгийг олгодог юм байна. Тэгээд бид бас энэ Боловсролын зээлийн сангийн энэ эх үүсвэрийг ер нь бол 300, 500, 500 гээд ингээд жил жилдээ багш нараа богино хугацаанд англи хэлний сургалттай ийм

газрууд руу 1 сарын хугацаатай бэлдэж тэднийг англи хэлээр бас нэг ярих ийм чадвартай болгох ийм зорилтыг тавьж байгаа. Энийгээ хэрэгжүүлэхээр эхний тендер шалгаруулалтын ийм бэлтгэл ажил руугаа ороод явж байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа Мөнхтуяа гишүүн асуултаа асууна уу?

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Боловсролтой Монгол хүний баталгааг хангах асуудлаар асуулга тавьсан Эрдэнэболд гишүүндээ маш их баярлалаа. Боловсролтой монгол хүний баталгааг Монголын ирээдүйг бэлдэж байгаа багш нар л хангана даа. Энэ баталгааг хангахын тулд багш нарын нийгмийн асуудлыг л ярина. Өнөөдөр боловсролын салбарт ажиллаж байгаа багш ажилчид маань ямар цалин аваад яаж амьдарч байгааг бид нар бүгдээрээ мэдэж байгаа.

2017 онд багшийн цалин таван зуун гучин тавхан мянган төгрөг байсан. Тухайн үед бид нар мөн л долларын ханш мянгад хүргэ гээд ингээд тэмцэж явсан. Тэгээд 2017 онд тухайн үед нь асуудлыг төр засаг нь соргоогоор олж хараад шийдсэн бол өнөөдрийн энэ түвшинд хүрч ажил хаялтад тулахгүй байсан. Тэгээд л нэг жил болгон тав, зургаахан хувь нэмнэ. Энэ нь зүгээр нэг нохойнд угаадас хаяж өгч байгаа юм шиг л юм болж байна хатуухан хэлэхэд.

Тэгээд өнөөдөр сая төгрөгийн цалин гар дээрээ авч байгаа багш нар жагсахгүй гээд яах юм, тэмцэхгүй гээд яах юм. Тэгээд багш нарын нийгмийн асуудал ярингуут гөлөг төөрүүлж байгаа юм шиг өөр юм ярьдаг. Түрүүн сайд хэлж байна шүү дээ. Ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй гээд яриад байгаа юм. Тэгээд ялгаварлаад л байгаа шүү дээ. Хаана тэгш хүртээмж байгаа юм. 60, 70-аар нь чихэж суулгачхаад өнөөдөр тэгш хүртээмжтэй гэж ярьж суухаасаа ичээ боль. Ингэж худлаа үнэн ярьж цаг аргацааж хүмүүсийн цаг завьг ингэж хохироож Монголын мянга мянган ирээдүйг бэлтгэж байгаа багш нарыг хохироож Монголынхоо ирээдүй рүү бид нар буу шагайж байгаа шүү яг үнэндээ хатуухан хэлэхэд. Тэгээд 1 итгэлцүүр гээд бас нэг гөлөг төөрүүлсэн юм гаргаад ирсэн. Тэр нь баахан хүүхдийн эрх зөрчөөд явж байгаа багш нарын эрхийг зөрчиж байгаа. Энийг нь хэлэнгүүт шал өөр юм урдаас ярина. Одоо тэгээд Боловсролын ерөнхий хуулийн 13.3-д заасан 5, 3 жилийн тэтгэмжид байхгүй. Туж асуугаастай. Энэ 5, 3 жилийн тэтгэмж хэзээ орох вэ гээд. Тэгээд энийгээ шийд л дээ. Тэр байгууллагын болон багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ гээд хачин холион бантан хийчихсэн. Одоо энэнийх нь юу нь байхгүй. Үнэлгээнийх нь 9 сард өгөх ёстой урамшууллынх нь мөнгө хүртэл ороогүй. Энийгээ хэзээ өгөх юм. 2025 оны төсвийн тодотгол батлагдахад нийслэлийн 117 багшийн тэтгэвэрт гарахдаа авдаг 36 сарын тэтгэмжийг хассан.

Тэгээд сайдад хэлэнгүүт асуудлыг шийднэ гэсэн. Одоо энийг яаж шийдэх гэж байгаа юм. Ямар ч мэдээлэл байхгүй. Иймэрхүү байдалтай байна аа. Тэгээд энэ хуулийг жил болгон өөрчилж болохгүй гэж яриад байх юм. Амьгүй хуулийг чинь өөрчлөхгүй гээд яах юм бэ. Тэгээд амьгүй хуулиараа хүн хуураад явж байх юм уу? Чихэр долоолгож байгаа юм шиг шилний цаанаас. Ямар ч бодлогогүй ингээд яваад байх юм. 2017 оноос хойш үе шаттай цалинг нэмсэн бол өнөөдөр багшийн цалин доор хаяж 3 сая 500 болчихсон.

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Тэгэхээр Мөнхтуяа гишүүний энэ яриад байгаа байр суурийг дэмжиж байгаа юм аа. Энэ жил жилдээ бараг үнэхээрийн туйлын бага хэмжээгээр нэмсээр байгаад тэгээд өнөөдөр бас одоо нэг үндсэн цалин нь 1 сая 483 мянга дээрээ. Гүйцэтгэлүүд нь янз янзын үнэлгээнүүд нь янз янзын нэмэгдлүүд нь ороод ингээд явахаараа зэрэг тэр үндсэн цалинтайгаа 100 хувь, 150 хувь бараг ингээд болчихсон ийм цалингийн бүтэцтэй болчихсон. Үндсэн цалин нь яагаад ч амьдралд хүрэхгүй болчихсон. Тэгээд энэ. Энэ олон жил хуримтлагдсан асуудлууд мөнөөс мөн.

Тэгэхээр энэ дээр бид адилхан байр суурьтай байгаа гэж ойлгож байгаа шүү дээ Мөнхтуяа ах гишүүнээ. Бид энэ нэмэх тал дээр нь, нэмүүлэх тал дээр нь яг одоо энэ дээрээ багш нараа дэмжих тал дээр хатуу байр суурьтай байгаа. Зүгээр тэр гүйцэтгэлийн үнэлгээнүүд орчихсон, орсон байгаа шүү орсон байгаа. Юуны хувьд бол 3, 5 жилийн тэтгэмжийн асуудал энийг бид энэ Сангийн яаманд тавьж оруулъя. Заримд нь ороогүй байх магадлалтай. 10-аас 12 сард санхүүжүүлэхээр тавигдаж байгаа гэсэн ийм юм хэлж байна. Ийм нөхцөл байдалтай байгаа. Бид мэдээж хууль амьдралд нийцэхгүй бол солих тал дээр нь ярина. Гэхдээ бид хуулиа өөрчлөхөөсөө өмнө эхлээд хэрэгжүүлэх гэж бүхий л талаас нь үзэх л хэрэгтэй.

Тэрний дараа үнэхээрийн болохгүй байвал хуулиа бас өөрчлөх ийм боломжууд байдаг аа. Энийг хүлээн зөвшөөрнө. Баярлалаа.

117 багшийн мөнгийг сайдын багцаас зохицуулж хийж олгохоор ажиллаж байна.

Л.Энхнасан: Галбадрах гишүүн асуултаа асууна уу?

Ж.Галбадрах: Эрдэнэболд гишүүндээ баярлалаа.

Маш чухал асуулга тавьжээ. Тэгээд энэ асуулгад одоо Улсын Их Хурлын гишүүн ч тэр нөгөө хуульчид ч тэр маш олон янзаар ингээд хариулдаг. Тэрний үндсэн хуулийн тэр 16.7 гэж заалт байна. Монгол Улсын иргэн бол сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно оо, иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно оо гэсэн заалт байгаа юмаа. Тэгээд энийг хөндөж тавьж байна. Тэгээд үүний төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэдгийг та бүхэн маань яамныхан маань сайд маань юу гэж ойлгодог тухайгаа тайлбарлаж өгөөч ээ. Анх Үндсэн хуулийг гаргаж ирж байх үеийн Чимэд багшийн тайлбарыг уншиж байхад бол ирээдүйн хүүхэд багачууддаа чанартай боловсрол эзэмшүүлэх энд анхаарч ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийнэ гэсэн үзэл баримтлалд үндэслэн бүх нийтийн боловсролыг төр 100 хувь хариуцаж даана гэсэн энэ утга санаа байдаг аа. Энэ талаар тайлбар сонсьё оо.

Дараа нь хувьсах зардлын асуудал байна. Энэ хувьсах зардлын задаргааг хэлж өгөөч? Төрийн өмчийн ЕБС-ийн нэг сурагчид өнөөдөр яг хэдэн төгрөгийн юу дунджаар очиж байгаа вэ? Тэрийг бас итгэлцүүрт ингээд оруулчихсан байгаа хүүхдийн тооноос хамаараад. Энэ хүүхэд цөөн байх юм бол тэрийг ихээр үржүүлж өгдөг, хүүхэд нь олон болох юм бол багасгадаг гээд. Энэ нь бас зөв шийдвэр байна уу үгүй юу? Дараа нь тэр шийдвэрийг бас тайлбарыг нь сонсьё.

Дараа нь цэцэрлэгийн нэг хүүхдийн хувьсах зардлыг хэлж өгөөч ээ. Энэнтэй холбогдуулаад ер нь зүгээр хувийн сургуульд итгэлцүүр байгааг сонслоо. Төлбөрөөс нь хамаараад. Тэгвэл хувийн сургуулийн хувьсах зардал ер нь яг тогтоогоод дунджаар тэр төрийн сургуулийн өгч байгаа юунаас хэдэн хувь нь хувийн сургуульд ингэж тооцдог юм. Тэрнээсээ хэдэн хувь олгох байснаасаа хэдэн хувийг нь хэмнэсэн юм. Одоо хэдэн хувь тэр төсөвт байж байгаа тоог бид нар мэдээд байгаа.

Дараагийн нэг юм бол нэг хүүхдэд оногдох хувьсах зардлын тодорхой хувь нь ингээд 3 хуваачихсан байдаг. Багш нарын урамшуулал, дотоод тогтмол зардлуудад гээд байдаг. Энэ дотроос яг багшийн цалинд оногддог нь хувиар хэлбэл нэг хүүхдэд оногддог нийт хувьсах зардлын хэдэн хувь нь энэ багшийн цалинд зарцуулагддаг юм бэ? Үнэхээр тэр цалин зарцуулагддаг байдлаараа яваад байна уу, эсвэл тэр сургуулийн бусад зардал тогтмол зардал, дулаан цахилгааны зардал ч гэдэг юм уу засвар үйлчилгээний зардал ч гэдэг юм уу тэр урамшууллын зардалд нь яваад байна уу. Энийг яг одоо багшийнх нь оногддог цалинд нь оногдох гэдэг хувиар нь бид нар ингээд яг 100 хувь зарцуулж өгч чадаж байгаа юу гэдгийг асууя.

Л.Энхнасан: Баярлалаа Наранбаяр сайд хариулна уу?

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр би энэ нарийвчилсан тоог манай Должинсүрэн хувьсах зардлын задаргаан дээр нь шууд тайлбарлаж хэлээрэй. Юуны хувьд бол иргэд хувийн өмчийн сургууль байгуулж ажиллуулж болно оо гэсэн ийм Үндсэн хуулийн заалт байдаг. Үнэ төлбөргүй сургана гэсэн энэ заалт бол ер нь ингээд ажиглаж байхад ер нь бидний ойлгосноор хэлэхэд бид энэ Монгол хүн Монголын иргэн болж төрөхдөө хувьсах зардлаа авч төрдөг л гэж ойлгодог. Өөрөөр хэлэх юм бол хаана сурах нь хамаагүй. Тэр байтугай гадаадад Монгол сургуульд сурч байгаа Монголын иргэн хүүхэд иргэн хувьсах зардлаа авч байгаа шүү дээ. Жишээ нь Солонгост ч байна. Бид энэ Туркт сурч байгаа Монгол хүүхдүүддээ хувьсах зардлыг нь олохоор ярьж байна. Энэ ийм зарчмаар явах ёстой юм аа. Ийм зарчмаар явах ёстой. Тэгээд хувийн сургууль байгуулаад ингээд боловсролын салбарт хөрөнгө оруулж байгаа бол энэ асар их хариуцлага гэж хардаг. Энэ чинь 12 жил дампуурах эрх байх ёсгүй шүү дээ. Хүүхдээ сургах ёстой. Багш нараа ажлын байраар хангах ёстой, өрсөлдөхүйц цалин өгөх ёстой. Ингээд явж байгаа ийм байгууллагууд гэж хардаг.

Тэгээд энэ дээр сурч байгаа хүүхдэд бол яахын аргагүй цаанаасаа ингээд төлбөр авдаг учраас энэ төлбөртэй нь уялдуулаад 10 саяас дээш төлбөр авдаг бол улсаас хувьсах зардал битгий ав, үлдсэн хүүхдүүдэд нь боломжийг нь түлхүү олгоё оо л гэсэн ийм л бодлого явж байгаа юм. Үндсэн зарчим нь энэ. Ерөөсөө хувьсах зардлаар дамжуулж энэ сурах боломжийг нь хангая гэсэн ийм зарчим явж байгаа.

Юуны хувьд бол тэр хувьсах зардал бол ер нь нэг дунджаар 2.2 сая төгрөг байж байгаа. Эндээс цэцэрлэг нь арай илүү байгаа. Тэгэхээр энэ дээр тэр зардлын юу дотор яг багшийнх энэ жил бид нар 100 тэрбум эд нарыг яг хувьсах зардлаар дамжуулж олгож байгаа учраас энэ жоохон тоо нь ингээд хөдөлнө. Энийг манай Должинсүрэн дарга нарийвчлаад хэлээд өг.

Л.Энхнасан: 6 дугаар микрофон Должинсүрэн дарга. Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн.

С.Должинсүрэн: Хувьсах зардлыг Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор бага, дунд, ахлах гэж гэж явж байгаа 53 дугаар тогтоолоор 1-ээс 12 дугаар ангид харилцан адилгүй тогтоосон. Тухайлбал 1 дүгээр ангийн хүүхдэд 1397, 5 дугаар ангийн хүүхдэд 1567, 12 дугаар ангийн хүүхдэд 2125 байж байгаад энийг нөгөө нэг Боловсролын ерөнхий хууль дээр хувьсах зардлыг 2.2 сая. Тэгээд нөгөө 2 жил тутам шинэчилнэ гэж яасны дагуу бид нар Засгийн газрын тогтоолын төслөө бэлдээд энэнийхээ дагуу Сангийн яаманд хянуулаад 2026 онд өргөн барьсан. Энэ нь бол 5.7 хувийн өсөлттэй байгаа.

Хувьсах зардлын ангиллыг ярих юм бол суурь хувьсах зардал, бусад хувьсах зардал гэж 2 ангилж байгаа. Суурь хувьсах зардлын хувьд болохоор багшийн үндсэн цалин түүнд ноогдох НДШ, багшийн нэмэгдэл хөлс түүнд ноогдох шимтгэл, хичээл сургалтын үйл ажиллагааны зардал нь болохоор суурь хувьсах зардалдаа ороод бусад хувьсах зардал.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 6 дугаар микрофон.

С.Должинсүрэн: Бусад хувьсах зардлын хувьд болохоор захиргаа аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар ноогдсон үндсэн цалин, ноогдох шимтгэл, захиргаа ажилтны нэмэгдэл хөлс мөн цэцэрлэгийн үйл ажиллагааны урсгал болон ариутгал цэвэрлэгээний зардал, хүүхэд хамгааллын зар, дал багшийн хөгжлийн зардал, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал мөн нөхөн хангалтын хувьсах зардал гэсэн ийм ангиллууд орсон байгаа. Хувьсах зардал дотор багшийн яг цалин яаж эзэлж байна? Цалингийн хувь яаж эзэлж байна вэ гэвэл багшийн үндсэн цалин түүнд ноогдох нийгмийн болон ЭМД-ын шимтгэл, нийслэлийн хувьд болохоор нийт хувьсах зардлын 44.3 хувь аймгийн хувьд нийт хувьсах зардлын 40 хувь, сумын хувьд бол нийт хувьсах зардлын 36 хувь. Багшийн нэмэгэл хөлсний хувьд болохоор нийслэлд 12.5, аймагт 16.7, суманд 20.7 хувь гэх мэтчилэн байгаа.

Тэгээд 2026 оны төсөв дээр болохоор СӨБ-ын хувьд нийт 34271 хүүхдэд 60.2 тэрбум, ЕБС дээр.

Л.Энхнасан: Гүйцээгээд хариулна уу?

С.Должинсүрэн: ЕБС-ийн хувьд болохоор төрийн бус нийт 74234 байгууллагад 41.5 тэрбум төгрөгийг олгохоор 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэболд гишүүн асуултаа асууна уу?

Дэгийн тухай хуулиар надад 5 минутын үг хэлэх боломж байгаа дараад нь. Тэгэхээр одоо Наранбаяр сайд нийтдээ 9 хуудас материал ирүүлсэн уншиж танилцсан байгаа. Саяын гишүүдийн асуулт дотор хариулаагүй тэгэхдээ чухал гэсэн зүйлүүдэд та одоо энэ хугацаанд нөхөөд хариулчихгүй юу. Тэгээд би дараад нь үгээ хэлчихье.

Л.Энхнасан: Наранбаяр сайд хариулна уу.

П.Наранбаяр: Баярлалаа. Ийм боломж олгож байгаа Эрдэнэболд гишүүндээ талархал илэрхийлье.

Өнөөдөр боловсролын салбарт бид яг энэ төсөв хэлэлцэж байгаа ийм чухал үед ингэж энэ хороо маань хуралдаж ажил хэрэгч ийм яриа өрнүүлж байгаад би Боловсролын сайдын хувьд үнэхээрийн талархаж байна. Та бүхэнд үнэхээрийн чин сэтгэлээсээ талархаж байна. Ямар хэцүү байдалд Улсын Их Хурал байгаа билээ? Ямар хэцүү байдалд өнөөдөр Засгийн газар ажиллаж байгаа билээ. Тэгэхэд энэ хороо маань ингэж ажил хэрэгчээр төсвөө ярилцаж байгаа юм. Багш нарынхаа цалинг нэмэх талаар ярилцаж байгаад боловсролын зээлийн сангийн хөрөнгийг багшийн хөгжилд зориулах энэ талаар санал тавьж байгаад мэргэжлийн боловсролыг дэмжих орон нутгийн сургуулиудыг дэмжих Дээд боловсролын сургуулиудыг дэмжих, түүний зэрэгцээ өнөөдөр захирал эрхлэгчийг томилоход хүндрээд байгаа бэрхшээлийг дүйцүүлэх байдлаар ингэж шийдвэрлэхийг ингэж зөвлөж хэлж байгаа Улсын Их Хурлынхаа гишүүдэд би үнэхээрийн их талархаж байна.

Хоёрдугаарт энэ жилийн төсөв дээр бид хөрөнгө оруулалт тал дээрээ АХБ-тай хамтраад төсөв энд хэрвээ ингээд батлагдах юм бол бид хөрөнгө оруулалтаа 2 дахин нэмнэ.

Нэг их наяд 41 тэрбум руу орно. Энэ бол боловсролын тэгш хүртээмжийг бүрдүүлэхэд энэ тодорхой хувь нэмэр болно оо гэж. Мэдээж бүрэн шийдэж чадахгүй.

Хоёрдугаарт бид цалингаа ядахдаа 25 хувь өсгөөд 1 сая 850 мянгад үндсэн цалин. Эндээсээ нэмэгдлээ тооцоод явбал багшийн цалин дорвитой нэмэгдэж эхэлнэ. Ирэх 2026 он гэхэд бид 2.5 саяд хүргэх ийм зүйлийг Улсын Их Хурал дээр маань дэмжээд өгөөч ээ. Ингэх юм бол энэ боловсролын салбарт багшлах илүү чадварлаг илүү сайн хүмүүс ч гэсэн сонирхол нь илүү сайн болж эхэлнэ. Өнөөдөр ажиллаж байгаа багш нар урам зоригтой ажиллаж эхэлнэ ээ.

Энэ боломжийг олгоход Улсын Их Хурал маань бидэнтэй хамтран ажиллаач ээ. Энэ зүйлийг та бүхнээс хүсэх гэсэн юм. Мөн ирэх жилд бид бас өнөөдөр энэ Боловсролын яамны Нэгдсэн бодлогын газрын даргаар ажиллаж байсан энэ туршлагатай Оюунаа гэдэг хүнийг бид яагаад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр томилж ажиллуулсан бэ? Энэ бол сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг бид эрчимжүүлэх зорилгоор ийм томилгоог хийсэн. Сургалтын өнөөдрийн хөтөлбөрийг, сурах бичгийг бид одоо яг өөрчлөх цикл дээр ирсэн. СӨБ нь өнөөдөр батлагдаад явж байна. Одоо бага боловсрол, дунд боловсрол, ахлах боловсролын энэ сурах бичгүүд хөтөлбөрүүд батлагдах ёстой. Бид дэлхийтэй зэрэгцэж алхах ийм л хөтөлбөрийг хийх ёстой. Түүний зэрэгцээ эх оронч хамгийн гол нь Монгол Улс эх орноо 1 дүгээрт тавьдаг, ээж аавыгаа энэрдэг, хайрладаг, гэр бүлээ ивээдэг, тэтгэдэг, Монгол уламжлалаа мэддэг, хайрладаг, өөрийгөө хайрладаг, өрөөлийг хайрладаг, өрөөлд тусалж өрөөлд талархах сэтгэл бусдад ийм талархах сэтгэлтэй ийм иргэдийг бий болгох.

Л.Энхнасан: Нэмж нэг минут.

П.Наранбаяр: Аз жаргалыг ойлгодог. Аз жаргалыг бусдад бэлэглэж чаддаг ийм хүмүүсийг бий болгох ийм эх оронч ирээдүйг авч явах Монголын дэлхийг ойлгодог, дэлхийтэй зэрэгцэж явдаг, ирээдүйд Нобелийн шагнал ч авах хэмжээний ийм хүмүүсийг бий болгоход энэ сургалтын хөтөлбөр маань чиглэх учиртай.

Тэгэхээр зэрэг ийм байдлаар бид бас бодлогуудаа томъёолж байна. Багшийн хөгжлийг 1 дүгээрт тавьсан ийм жилүүд байх болно. Энэ багшийн хөгжил багшаа тасралтгүй дэмжих энэ 3 тулгуурт бодлогыг бид үргэлжлүүлж явна аа. Өмнөх өмнөх сайд нарын боловсруулсан сайн бодлогыг миний үе дээр хэрэгжүүлж байгаа. Ямар нэгэн бодлогыг нь няцааж ямар нэгэн бодлогыг нь зогсоосон юм байхгүй. Бүгд л Монголын боловсролын төлөө сайн сайхны төлөө зүтгэж ирсэн ийм төрийн зүтгэлтнүүдийн энэ боловсруулсан бодлого сайжруулсан зүйлийг нь аваад явж байгаа.

Ийм учраас өнөөдөр Улсын Их Хурал маань төсөв нь багшийнхаа орлогыг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн ийм сайн жил болно оо гэдэгт найдаж байна аа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Эрдэнэболд гишүүн үгээ хэлнэ үү?

С.Эрдэнэболд: Бид энэ боловсрол, эрүүл мэндийн асуудал дээр их тийм нам дор дуугаар ухаан зарж, бодит байдлыг ойлгож, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ярих шаардлагатай болчихоод байгаа юм. Ийм эмзэг сэдэв дээр бол их тийм хоорондоо ялангуяа хууль тогтоогчид маань хэдэр ёдор гэж, хэрэлдэж уралдаж популизм хийж ерөөсөө болохгүй. Ялангуяа энэ сэдвүүдээр улс төржиж ерөөсөө болохгүй. Энэ чинь үнэхээр энэ эх орны ирээдүй, энэ гэгээрэл гэрэлт ирээдүй ярьж байгаа бол бид энэн дээр яг шийдэл рүү чиглэж ярих ёстой.

Тэр шийдэл дээрээ яг мэргэн ухаанаа уралдуулж Монголын парламент хууль тогтоох замаар хяналт хэрэгжүүлэх замаар Засгийн газартаа чиглэл өгөөд хаана асуудал байна түүнийг нь оношилж ярихгүй болохлоор энэ нэг тийм морин туурайн төвөргөөн шиг хүчтэй салхи шиг болоод л дуусчихдаг. Эцсийн эцэст хохирч байгаа нь нөгөө багш нар, нөгөө салбарынхан. Тэгээд хүүхдүүд Монголын ирээдүй хохирч байгаа юм. Өнгөрсөн жил би Дархан, Сэлэнгэ, Төв аймгаас сонгогдсон учраас манай 3 аймгийн 69369 хүүхдэд 1-ээс 12 дугаар ангийн хүүхдэд захиа бичсэн юм. Тэгээд ноднин жилийн хүүхдүүдээс ирсэн хариу энэ ихэнх нь сургуулийн орчны аюулгүй байдалтай холбоотой зам гарах, нохой ч гэдэг юм уу тэр сэдвүүд зонхилж байсан.

Энэ жил Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн 72331-ээс 12 дугаар ангийн хүүхдүүдэд захиа бичсэн. Ингээд энэ хүүхдүүдийн ирж байгаа 4 мянга гаран хариу захиаг зарим нь цахимаар зарим нь цаасаар ярьж байгаа. Дүн шинжилгээ хийгээд үзсэн хөөрхий багш нарын маань цалинг нэмэх боломж байна уу гэж байгаа.

Өнөөдөр нийт багш нарын төгсөөд гарч байгаа багш нарын 60 хувь нь 6 жилийн хугацаанд ажлаа өөрчилж байна. Энэ чиглэлээр ажиллахгүй байна гэж байгаа. Дахиад 60 хувь нь нэгээс доош сая төгрөгийн цалинтай. Яг үнэндээ хэцүү шүү дээ. Тогтвор суурьшилтай байж чадахгүй байгаа гол асуудал чинь л нийгмийн хангамжийн асуудал. Мөнхтуяа гишүүний хэлээд байгаа, Галбадрах гишүүний хэлж байгаа эдгээр асуудлуудыг би зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тэгэхээр хүний эрх талаасаа ч тэр, ерөөсөө энэ нийгэмд шударга бус байдлыг хүмүүс ингээд хүүхэд байхаасаа мэдэрч өсөж байгаа орчин чинь өөрөө энэ сургуулийн орчин болчихоод байгаа байхгүй юу ХЭҮК-оос хийсэн судалгаагаар орон

нутагт байгаа сургууль Улаанбаатарт байгаа сургуулийн чанар өөр зарим газар 2-оос 8 дахин ялгаатай байгаад байгаа юм. Энэ чинь эцэг эх нь хаана амьдарч байгаа, аль аймаг, аль сумд амьдарч байгаагаасаа болоод тэр хүүхдүүдийн Монгол Улсын иргэн хүний хувьд гарааны тэгш байдал хангагдахгүй байна гэдэг бол дахиад л шударга бус.

Тэгэхээр Монголын төр бол энийг нэг салбарын яамандаа 100 хувь даатгаад дуртай үедээ тэд нарыгаа шахдаг загнадаг гэхээс илүүтэйгээр бид нар аль ч тойргоос сонгогдсон бай хамаагүй Монгол төрийн түшээд л бол энчээ бүгдээрээ санаа зовж шийдэл дээр нь төвлөрч ярих зайлшгүй шаардлагатай болчихсон.

Дашрамд дурдахад энэ Стилиен Бош гэдэг сургуулийн нэг эшлэл их алдартай байдаг л даа. Энэ ӨАБНУ-ын. Аливаа улсыг сөнөөхөд атомын бөмбөг цөмийн зэвсэг хэрэггүй ээ. Англиар яг плажеризм буюу зохиолын хулгай хууран мэхлэлтийг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл чанаргүй боловсролын тогтолцооноос гарсан эмч нарын гар дээр хүмүүс нас барж, чанаргүй боловсролын тогтолцооноос гарсан хуульчдын гар дээр авлига хээл хахууль цэцэглэж, чанаргүй боловсролын тогтолцооноос гарсан инженерүүдийн барьсан зам гүүр нуран унадаг гэж. Аливаа улсыг эзлэн түрэмгийлэх, хорлон сүйтгэж, мөхөөн доройтуулна гэдэг ерөөсөө л боловсролын системийг нь хангалттай доройтуулахад болчихдог.

Тийм учраас энэ үндэсний аюулгүй байдлын сэдэв, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын сэдэв. Монгол Улсын хөгжил дэвшлийн гол амьд халуун дархлаа болсон сэдэв боловсролын сэдэв. Өнөөдөр энэ асуулгаар дамжуулж яагаад энэ асуудлыг санаачилсан гэхээр би ч ганцаараа санаачлаад байгаа биш. Бүгдээрээ л ярьж байгаа асуудал. Бүгдээрээ л зовниж байгаа асуудал. Багш нар маань ингээд хөхөө өвлийн хүйтэн болох гэж байна. Талбай дээр ингээд очоод хүйтэн цемент дээр 70, 80 хувь нь эмэгтэй хүмүүс байгаа шүү дээ. Тэгээд 1 картонон цаас тавьчихсан, тэр нь юу л ажрааж, тэгээд л шууд л доороосоо өвчтэй болохоор байгаа байхгүй юу. Ингээд нэг элэг зүрх эмтэрмээр л юм болоод байгаа юм. Энийг бид нар ингээд нэг зүгээр хараад байдаг л нэг жагсаал болдог л нэг цуглаан биш. Тэр хүмүүс чинь тэнд очоод ажлаа хийж байх ёстой, адаглаад л эрүүл дээрээ хохирч болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ ингээд нэг яам, Их Хурал гэж тал тал болохоос илүүтэйгээр зүгээр яг Монголын төр юм чинь нэг талаас асуудлыг авч үзээд үнэлж дүгнээд шийдлүүдээрээ төвлөрөөд ажиллая гэдэг л энэ нээлтийн хуралдаан л болж байна гэж үзэж байгаа юм. Тэгээд ингээд цаашлаад ажилламаар байна. Үүрийнтуяа гишүүн манай Зулпхар гишүүний хэлж байгаа, Галбадрах гишүүний хэлж байгаа, манай Мөнхтуяа гишүүний хэлж байгаа.

Л.Энхнасан: Дуусгая 1 минут.

С.Эрдэнэболд: Тэр энэ Эрдэнэбат гишүүн дээр би гарын үсэг зурсан. Тэр багш нарын цалин хангамжийг нэмэх асуудал дээр өөрөөр хэлбэл улсад мөнгө байхгүй биш байна. Бүгд ойлгочихсон. Үр ашигтай эрэмбэтэй, тооцоолол судалгаатай энэ мөнгийг менежмент хийж захиран зарцуулж чадах юм бол янз бүрийн хулгайд автаад байгаа тэдгээр төсвүүдийг боловсрол, эрүүл мэндийн салбартаа зарцуулах ухаалаг төрийн бодлогыг л эрхэм гишүүд та бүхэн маань бид бүхэн хийх ёстой гэж харж байгаа юм.

Чойлуvsсанжав гуайн үгийг эш татаж хэлмээр байна. Хүн чанаргүй хүнд өндөр боловсролыг эзэмшүүлбэл босоо ороолонд алтан шүд хийгээд босгохтой адилхан гэж байгаа юм.

Боловсрол гэдэг бол зөвхөн энэ дипломоор хэмжигдэж байгаа зүйл биш. Энэ боловсролын салбарт цаад тал нь хүн чанарыг, хүмүүжлийг, хүн байх ухааныг, Монгол соёл, өв уламжлалаа танин мэдсэн дэлхийтэй өрсөлдөх чадамжтай тэр бие хүмүүсийг бид нар төлөвшүүлэх тухай байтал тэр ажлыг даатгаад байгаа тэр багш нарыгаа бид нар ингээд хайхрахгүй өнгөрөөд байна гэдэг бол.

Л.Энхнасан: Баярлалаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболдоос боловсролтой Монгол хүний баталгааг хангах талаар Боловсролын сайдад хандсан асуулгын хариуг сонсож дууслаа.

Ингээд ажил хэрэгч Байнгын хорооны хуралдаа оролцсон бүх гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн хурлыг дууссаныг мэдэгдье ээ.

14.16 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА